



"ГЛОБ ИНТЕРНЭШНЛ" ТББ



НЭЭЛТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ТӨРӨӨС МЭДЭЭЛЭЛ ХЭРХЭН ОЛЖ АВАХ ВЭ?



СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот. 2007 он

Мэдэх эрхийн үндэс
Эрх чөлөөний баталгаа
Дэвшил хөгжлийн түлхүүр
Эрх мэдлийг тэнцвэржүүлэгч
Эв нэгдэл, шударга ёсыг хангагч
Луйвар авилгыг илчлэгч
Эрх тэгш боломжийг бүрдүүлэгч
Либерал ардчиллын мөн чанар

Энэхүү гарын авлагыг Нээлттэй Нийгэм Форум, Лондон дахь Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн сүлжээний санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн хүрээнд “Глоб Интернэшнл” ТББ-аас эрхлэн гаргав.

Published by Globe International in the framework of the project “Monitoring Free Expression Violations and Supporting the Rights of Independent Media” funded by Open Society Forum (Mongolia) and OSI, Media Network Programm (London).

**Бэлтгэсэн: Х.Наранжаргал
Г.Даваахүү**

ISBN:

“Чөлөөт Хэвлэл Сан” СХҮ-т эхийг бэлтгэж, хэвлэв.

СЭТГҮҮЛЧ ТАНАА

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага сэтгүүлч танд ээлжит гарын авлагаа өргөн барьж байна.

Төрөөс мэдээлэл авах нь сэтгүүлч таны олон талт мэргэжлийн үйл ажиллагааны зөвхөн нэг хэсэг, төрийн байгууллагад хадгалагдаж буй мэдээлэл сэтгүүлчийн эх сурвалжийн гагцхүү нэг л хэлбэр болох нь мэдээж. Гэвч төрийн аливаа байгууллагаас мэдээлэл авах нь хэн нэгэн албан тушаалтны хувийн өмчийн эд хөрөнгийг түрэмгийлэн булаах, түр зээлэх, үзээд өгөх, үрж ашиглах гэсэн мэт сэтгэлгээ зонхилж буй өнөөгийн нөхцөлд тэднийг өөртөө үйлчлүүлж сургах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, нийгэмд нээлттэй мэдээллийн соёл бий болгож төлөвшүүлэх нь чухал юм. Үүнд сэтгүүлч та туйлын өндөр үүрэгтэй.

Юуны түрүүн та өөрөө төрийн байгууллагаас мэдээлэл авч сурсанаар бусдад ийм боломж олгох, нөхцөл бүрдүүлэх, эрх зүйн орчин бий болгоход үнэлж баршгүй хувь нэмэр оруулж чадна.

“Ямар зорилгоор энэ мэдээллийг авах гэж байгаа юм бэ?” хэмээн хэн ч танаас асуух ёсгүй. Учир нь та энэ улс орны иргэн, төрийн эзэн. Төрийн байгууллагаас мэдээлэл хүссэнээр та Үндсэн Хуулиар баталгаажуулсан хүний үндсэн эрх, эрх чөлөөг эдэлж байгаа хэрэг. Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн бүхэн “амьд явах эрхтэй”. Хэн ч хэзээ ч хэнээс ч “Чи яах гэж амьд явж байгаа юм бэ?” гэж асуудаггүйтэй адил.

Мэдээлэл бол эрх мэдэлтний бус, таны өмч. Гэхдээ та өөрийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс зарим мэдээллийг нууцлах эрхийг өөрийнхөө төлөөлөгчид өгсөн. Харин эрх мэдлээ хэтрүүлэн хуулийн нэр барин иргэнийхээ мэдвэл зохих мэдээллийг ч нууцлах боломжийг тэдэнд олгох ёсгүй.

Харамсалтай нь бүхнийг нууцалдаг хуучин дэглэмийн соёлыг бид бүрэн мөсөн өөрчилж чадахгүй өдий хүрчээ. Нээлттэй, ил тод, цэвэр тунгалаг, ёс зүйтэй, хариуцлагатай төрийн төлөө иргэдийн өмнөөс хяналт тавих нь бидний үүрэг.

Мэдээлэл нээлттэй байх эрх зүйн зохицуулалт, хэм хэмжээ бидний хүссэн хэмжээнд хангалттай бус ч бас боломж байгаа юм. Үүнийг үр дүнтэй ашиглахад тань тус болох үүднээс энэ гарын авлагыг бэлтгэлээ.

Өнөөдрийн байдлаар Монголд 360 орчим хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнээс мэдээлэл ил тод, нээлттэй байх зарчим, хэм хэмжээг зохицуулсан 120 гаруй хууль байна. 2006 оны долоодугаар сарын 06 -ны өдөр төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал, мэдээллийн эрх чөлөөг хангах чиглэлээр нэлээд шинэлэг зохицуулалт хийсэн Авлигын эсрэг хууль батлагдсан юм.

Энэхүү гарын авлагаас та мэдээллийн эрх чөлөө, төрийн байгууллага ил тод, нээлттэй байхын утга учир, мэдээлэл, нууцтай холбоотой эрх зүйн зохицуулалтын тухай ойлголттой болно. Түүнчлэн төрийн байгууллагын эрх мэдэлтэн, албан тушаалтан, албан хаагчтай харилцах, төрийн мэдээллийг ашиглахтай холбоотой сэтгүүл зүйн зөвлөмжийг багтаав.

Мөн таны өдөр тутмын ажил үйлст тус болох үүднээс мэдээлэл ил тод, нээлттэй байхтай холбоотой хуулийн зүйл заалтын түүвэр, төрийн мэдээлэл авч болох зарим вэб сайтын хаягийг хавсаргав.

Бидний хичээнгүйлэн бэлтгэсэн энэ гарын авлагаас олж авсан мэдлэгээ ашиглан мэргэжлийн үйл ажиллагаанд тань сэтгүүлч та өөрийн ажил үйлсэд тохиолдох аливаа саад бэрхшээлийг эрх зүйн хүрээнд амжилттай даван туулах болно гэдэгт бид найдаж байна.

Танд олон нийтийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой аливаа мэдээллээр цаг ямагт иргэдийг хангаж, тэдний өмнөөс төр засагт хяналт тавих нийгмийн **“ХОТОЧ НОХОЙ”** байх үүргээ нэр төртэй биелүүлэхийг хүсье.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын тэргүүн Х.Наранжаргал

ТӨР СЭТГҮҮЛЧИД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮҮРЭГ ХҮЛЭЭДЭГ ҮҮ?

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт: “Монголын ард түмэн бид ... эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно ...” гэсэн билээ.

Ардчилсан төр зөвхөн сэтгүүлчид ч бус, жирийн иргэн хэнийг ч мэдээллээр хангах үүрэгтэй. Энэ нь төрийн үндсэн үйл ажиллагааны салшгүй хэсэг, төрийн үйлчилгээний зайлшгүй нэг хэлбэр юм. Үнэнийг олж мэдэх олон нийтийн эрх ашигт үйлчлэх нь сэтгүүлчийн эрхэм зорилго, засаглалын бүх хэлбэр, төрийн бүх байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих нь ардчилсан, хариуцлагатай, ёс зүйт хэвлэл мэдээллийн үндсэн үүрэг. Иймд төрөөс мэдээлэл хүсэх, шаардах нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааны үндсэн хэсэг билээ.

Төр нь хүмүүсийн өөрсдөө бодож олсон зохион байгуулалтын хэлбэр юм. Угтаа үүсмэл, хийсвэр зүйл гэсэн үг. Төрийг нэгэнт хүмүүс өөрсдөө үүсгэн байгуулсан тул тухайн улсын иргэн хэн ч гэсэн адил тэгшээр төрийн үйл ажиллагаанд оролцох, төрийн эрх барих эрхтэй байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн тунхаглаж, дээрх эрхийг баталгаажуулсан байна.

Иргэд өөрийн байгуулсан төрийг өөртөө үйлчлүүлэхийн тулд татвар өгч, өөрөөр хэлбэл халааснаасаа санхүүжүүлдэг.

Иргэдийн шууд оролцооны эрхийг бодитой хэрэгжүүлэхийн үндэс нь мэдээлэлтэй байх жам ёсон билээ.

- Иргэн сайн, үнэн мэдээлэлгүй бол сонгууль шударга болохгүй, сонгогч зөв сонголт хийх боломжгүй.
- Иргэн сайн, үнэн мэдээлэлгүй бол өөрийн итгэж сонгосон эрхэм түшээд, тэдний хяналтад байх ёстой Засгийн газар, түүний байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагааг хянах, булхайг илрүүлэх, буруу шийдвэрийг эсэргүүцэх, засаж залруулахыг шаардаж, шударга ёсыг тогтоож чадахгүй.
- Иргэн сайн, үнэн мэдээлэлтэй байх эрхийг хуулиар баталгаажуулахгүй бол төрийн хэрэгт шууд оролцож чадахгүй

Нэгдсэн Үндэсний Байгууллагын анхдугаар чуулганы 59 дүгээр тогтоолд “Мэдээллийн эрх чөлөө бол хүний үндсэн эрх... бөгөөд НҮБ - ийн эрхэм зорилго болсон хүний бусад бүх эрх, эрх чөлөөний тулгын чулуу юм.”¹ гэжээ.

Мэдээллийн эрх чөлөө гэдэг нь мэдээлэл хайх, хүлээн авах, олж авах, түгээх бүлэг эрх юм. Энэ улсын иргэн бүр энэ цогц эрх чөлөөг бүрэн дүүрэн эдэлж, өөрөө мэдээлэл цуглуулж, боловсруулж, дүн шинжилгээ хийж, хяналт тавих боломжгүй тул эрхээ хэвлэл мэдээллээр дамжуулан эдэлдэг. Иргэн өөрт нь үйлчилдэг хэвлэл мэдээлэлд итгэж, өөрийнх нь өмнөөс төрийг хянах үүрэг хүлээлгэх нь түгээмэл. Нөгөөтэйгүүр, төр мэдээллийг татварын мөнгөөр хуримтлуулдаг тул энэ нь төрийн байгууллага, эрх мэдэлтний бус, харин нийт ард түмний өмч билээ.

Иймд сэтгүүлч ард түмний нэрийн өмнөөс мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх онцгой үүрэг хүлээдэг.

Монгол Улс ардчиллын хөгжлийг сонгон авч, 1992 онд шинэ Үндсэн Хуулиа батлахдаа түүнд дээрх үзэл баримтлал, үзэл санаа, хэм хэмжээг хүлээн зөвшөөрч, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодрхойлсон юм.

1 Монгол Улс шилжилтийн үед-Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ. 14 дэх тал.



“Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

ш 'S—э' >— ‘ЦТ’ кэ«SA«ээр КАТ ‘ЦТ’ 2 S^>Y>э—э«

Төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж төрийн байгууллага, албан тушаалтнууд төрийн аливаа үйл ажиллагааг эрхлэн явуулахдаа удирдлага болговол зохих үзэл санаа юм. Ардчилсан ёсны энгийн шалгуурын нэг нь ил тод, нээлттэй байдал билээ. Ийм ч учраас Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд² төрийн үйл ажиллагаа ил тод байх тухай заасан.

Ардчилал өндөр хөгжсөн орнуудад transparency нэр томъёо хэвшмэл хэрэглэгддэг. Бид ч “тунгалаг төр”-ийн тухай ярьж, бичдэг болсон. Энэ нь нэг талаас ил тод байдлыг бэлэгдсэн, ямар ч нууж хаах зүйлгүй, бүх үйл ажиллагаа нь нэвт шувт харагддаг гэсэн утгыг агуулсан хэллэг, нөгөө талаас тухайн төрийн үйл ажиллагаа нь хир буртаггүй, хууль бус явдал, шударга бус байдал, авилгаас ангид гэсэн ойлголт юм. Ер нь төр ил тод байснаар нийгэм цэвэр ариун байх нөхцөл бүрдэх нь дамжиггүй.

Төр тунгалаг байхад зөвхөн мэдээлэл нээлттэй байх нь хангалтгүй. Үүнд иргэдийн оролцоог хангах, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх боломжийг бүрдүүлэх гэх зэрэг цогц үйл ажиллагаа шаардагддаг байна. Ил тод, нээлттэй байдал нь ардчиллын соёлын салшгүй хэсэг. Жишээ нь, Шведэд төрийн байгууллагын бичиг баримт тэдгээрийг боловсруулсан, захидал материалыг хүлээн авч тамга дарсанаар олон нийтэд ил байх ёстой, Ерөнхий сайд нь өөртөө ирсэн захидлыг өөрөө эхэлж унших эрхгүй ажээ. Германы Үндсэн хуулийн шүүхийн барилгын бүх хана нь шилэн бөгөөд доторхи зүйлс нь гаднаасаа ил харагддаг байна.

СЭТГҮҮЛЧ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ МАНАЙД ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛСАН БЭ?

Мэдээлэлгүй иргэн Үндсэн Хуулиар баталгаажуулсан эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжгүй нь мэдээж. Ер нь аливаа улсад Үндсэн хууль нь эрх зүйн хамгийн гол хэм хэмжээний эх сурвалж буюу гол хууль нь байдаг. Үүнийг Үндсэн хуульт ёс гэж нэрлэх нь бий. Үндсэн хуультай байхын ач холбогдол нь иргэний эрх чөлөөг төрийн хууль бус үйл ажиллагаанаас хамгаалахад оршдог. Үүний тулд Үндсэн хуулийг баталж мөрддөг. Төр иргэддээ эрх чөлөө олгодог, харин иргэд нь төрөөс хайрласан эрх чөлөөг бурхны хишиг мэтээр ойлгож, өөртөө угаас заяасан жам ёсны эрхээ төрийн хайр ивээлээр эдэлж байгаа юм шиг ойлгодог буруу хандлага нийгэмд түгээмэл ажиглагддаг. Уг нь бол иргэд өөрсдийн эрх чөлөөгөө хамгаалуулж, эмх цэгц дэг журамтай орчинд аж төрөхийн тулд төрийг үүсгэсэн. Энэхүү үүсмэл зүйл нь өөрөө засаглах эрх мэдлээрээ дамжин дарангуйллын тогтолцоог үүсгэх нөхцөл боломжийг бүрдүүлдэг тул тийм байдалд хүргэхгүйн тулд төрийг эрх зүйгээр хязгаарлаж, ардчилсан байлгахын тулд Үндсэн хууль үйлчилдэг.

Иймд Монгол Улс иргэдийнхээ мэдээлэл хайх, олж авах эрхийг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17³ дахь хэсгээр баталгаажуулж өгсөн байдаг.

Үндсэн хуулийн дараа орох хүчин чадалтай, эрх зүйн хэм хэмжээ бол Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хууль, баримт бичиг, хэм хэмжээ юм. Эдгээрийн нэг нь 1966

2 Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн. 4.2. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд дараах зарчмыг баримтална: 4.2.2. ил тод байх...

3 “төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй...” /Монгол Улсын Үндсэн хуулийн 16.17./



онд батлагдсан Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пакт⁴ /цаашид Пакт гэх/ билээ. Монгол Улс үүнд 1974 онд нэгдэн орсон.

Мэдээлэлтэй байх эрх чөлөө нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний салшгүй хэсэг юм. Пактын оршил хэсэгт үүнд нэгдэн орсон улс орнууд, түүнчлэн тухайн улсын иргэн бүр энэхүү Пактаар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, дэмжих, зөрчихгүй байх үүрэгтэй болохыг заасан байдаг. Монгол Улс хэн нэгний албадлага, шахалтаар бус сайн дураараа нэгдэн орсон тул Пактын зүйл заалт бүрийг хэлбэрэлтгүй сахин, дагаж мөрдөх нь бидний, ялангуяа Монгол Улсын төрийн заавал биелүүлэх үүрэг юм.

ИБУТЭОУП-аас гадна бас нэгэн чухал баримт бичиг байдаг. Энэ нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал /цаашид ХЭТТ гэх/ юм. Гэхдээ ХЭТТ-ыг Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пакт, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн нэгэн адил бүх нийтээр заавал дагаж мөрдөх үүрэг хүлээдэггүй. Мөн ХЭТТ-ын 19 дүгээр зүйлд⁵ мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан байдаг.

ХЭТТ-ыг хэдийгээр заавал дагаж мөрдөх үүрэг байхгүй боловч Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гишүүн улсууддаа ХЭТТ-д заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэн үзэж өөрийн улс орон бүртээ хууль тогтоомжоороо баталгаажуулахыг уриалсан байдаг билээ. Мөн ХЭТТ-д орсон хүний үндсэн эрх, эрх чөлөөнүүдийг бүгдийг нь янз бүрийн гэрээ, конвенц, пакт гэх мэтийн баримт бичгүүдээр баталгаажуулж хамгаалсан байдаг учраас ХЭТТ-ыг өөрийг нь биш ч гэсэн түүнд орсон хүний үндсэн эрх, эрх чөлөөг бүгдийг нь хүндэтгэн үзэж, зөрчихгүй байх механизм нь хууль зүйн хувьд хангагдсан байдаг.

ТӨР МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ ШААРДЛАГАТАЙ ЮУ?

Ардчилсан нийгэмд бүх мэдээлэл нээлттэй байх үндсэн зарчим үйлчилдэг ч ямар нэг мэдээллийг ил болгосноор үндэсний аюулгүй байдалд ноцтой хор уршиг учруулж болзошгүй гэсэн үндэслэлээр нууцлахыг зөвшөөрдөг. Мэдээллийг нууцад хамааруулах нь мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах тухай ойлголт юм. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт төрөөс мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан байдаг тухай өмнөх бүлэгт бид үзсэн билээ. Тэгвэл энэ зүйлд мөн мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах буюу нууцлах зохицуулалтыг заасан байдаг.

“Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж заасан.

и'ᠰ-э' > — ЦТ' 16 S—< ^p КАТ' ЦТ' 17 S' > Y > —э<

Өмнөх бүлэгт дурдсан Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг⁶ мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, шаардлагыг тодорхой зааж өгсөн байдаг. Өөрөөр хэлбэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлахдаа зөвхөн бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахад зайлшгүй шаардлагатай бол хязгаарлаж болно. Гэхдээ гагцхүү хуулиар хязгаарлаж болдог. Хууль батлан гаргахгүйгээр мэдээллийн эрх чөлөөг ямарваа арга, байдлаар хязгаарлахыг хориглоно гэсэн үг. Хууль батлагдсан ч Пактад тухайлан зааснаас

4 Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй /ИБУТЭОУП-19.1/. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана / ИБУТЭОУП-19.2/.

5 Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана”

6 Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой. а/ бусдын эрх нэр төрийг хүндэтгэх, б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах. /ИБУТЭОУП 19.3/



өөр бусад үндэслэлээр хязгаарлалт хийх нь түүнтэй зөрчилдөнө. Энэ нь олон улсын өмнө хүлээсэн үүргээ бүдүүлгээр зөрчиж буйгийн илрэл юм.

ТӨР, БАЙГУУЛЛАГА, ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЯМАР ЗОХИЦУУЛАЛТ БАЙДАГ ВЭ?

Манай улсад нууц мэдээллийг хамгаалах зорилготой хэд хэдэн төрөлжсөн хууль байдаг. Үүнд:

- Төрийн нууцын тухай хууль,
- Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль,
- Байгууллагын нууцын тухай хууль,
- Хувь хүний нууцын тухай хууль
- Геодези, зураг зүйн тухай, СӨХ-ийн тухай гэх мэт салбар харилцааг зохицуулсан бусад хууль

Төрийн нууц

Манайд төрийн нууцтай холбоотой харилцааг Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар зохицуулдаг.

Төрийн нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой, бөгөөд дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ” гэж заасан байдаг.

Энэ хуулиар нууцад хамаарах мэдээллийн тодорхойлолт, хүрээ хязгаар, нууцлах хугацааг хэрхэн тогтоох, нууцын зэрэглэл, төрийн нууцыг ил болгох үндэслэл зэргийг заажээ. Уг хуулийн 5 дугаар зүйлд төрийн нууцын хүрээг үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил, цаазаар авах ялыг гүйцэтгэх гэж тодорхойлсон байна. Төрийн нууц нь онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэсэн зэрэглэлтэй.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар Төрийн нууцын тухай хуулинд заасан үндэслэл журмын дагуу нууцад хамааруулсан 59 төрлийн мэдээллийг төрийн нууцад хамааруулжээ. Мэдээллүүдийг нэгбүрчлэн нэрлэж заадаг.

Байгууллагын нууц

Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлд “байгууллагын нууц” гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ” гэжээ.

Хувь хүний нууцын тухай хууль

Төрийн нууц, байгууллагын нууцаас гадна хувь хүний нууц гэсэн ойлголт байдаг. Хувь хүний нууцын тухай хуулиар ерөнхийд нь гэр бүлийн нууц, эд хөрөнгийн нууц, эрүүл мэндийн нууц, захидал харилцааны нууц, бусад гэж хүний хувийн нууцыг ангилдаг. Бусад гэж заасан байгаа нь тухайн хүн өөртөө хамаатай ямар ч мэдээллээ нууцлах эрхтэй гэсэн үг. Мөн хувь хүн нууцаа өөрөө хамгаалах, шаардлагатай тохиолдолд төр, байгууллага хувь хүний нууцыг хамгаалалтдаа авч болох тухай уг хуулиар зохицуулсан байдаг. Энэ зохицуулалтыг ашиглаад хэн нэгэн албан тушаалтан өөрийнхөө хувийн нууцыг төрийн нууц гэж хэлж магадгүй. Хувь хүний нууцыг төр, байгууллага хамгаалалтдаа авч болох тухай заасан боловч төрийн болон байгууллагын нууцад хамааруулах тухай ойлголт



байж болохгүй. Түүнчлэн тухайн хувь хүний нууцыг төр, байгууллага хамгаалалтдаа авсан эсэхийг тодруулахад илүүдэхгүй болов уу.

Ардчилал хөгжсөн орнуудад төрийн өндөр албан тушаалтнуудад өөрт нь хамаатай зарим мэдээллийг нууцалж болохгүй талаар зохицуулсан байдаг. Учир нь төрийн өндөр албан тушаалтнууд бусдаас илүү хариуцлагатай байх ёстой учраас тэдний тухай олон нийт бодитой мэдээллээр хангагдаж байж элдвийн хардлага сэрдлэг үгүй болдог. Мөн ажлын хариуцлага дээшлэх, хууль бус үйл ажиллагаанаас ангид байлгах зэрэг сайн талуудтай. Ийм утгатай заалтыг 2006 оны долоодугаар сарын 06-ны өдөр шинэчлэн батлагдсан Авлигын эсрэг хуулийн 14.1-т оруулсан байна.

Гэхдээ тухайн хүний зөвхөн өөрт нь хамаатай нийтэд ил болгох шаардлагагүй мэдээллийг нууц байлгах эрхийг хувь хүнд үлдээх нь ардчилсан нийгэмд байх ёстой зүйл билээ.

АЛИВАА БАЙГУУЛЛАГА МЭДЭЭЛЛЭЭ НУУЦЛАХ ҮНЭМЛЭХҮЙ ЭРХТЭЙ ГЭСЭН ҮГ ҮҮ?

Ямар нэг төрийн байгууллагаас мэдээлэл авахыг хүсэхэд хэдийгээр төрийн нууцад хамаардаггүй боловч “манай байгууллагын нууц” гэж хэлж магадгүй. Тийм учраас та төрийн болон байгууллагын нууцад ямар ямар мэдээллүүд хамаардаг болох тухай тодорхой мэдлэгтэй болох зайлшгүй шаардлагатай юм.

Аливаа байгууллага өөрийн боловсруулж, хуримтлуулсан мэдээлэл бүрийг нууцлах үнэмлэхүй эрх байхгүй. Хэдийгээр Байгууллагын нууцын тухай хуулиар тухайн байгууллага нууцаа өөрөө тогтоож, нууц мэдээллийг хамгаалах журмыг батлах үүрэг ноогдуулсан нь аливаа мэдээллийг олж авах иргэний эрхийг хамгийн зохисгүй, зүй бусаар хязгаарлаж буй зүйл заалт боловч тодорхой мэдээллийг нууцлах үндэслэлийг хуульд бас заасан байна.

Байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно

3[^]Б<— “^h’ —sh’ ~> ^Б >— ‘ЦБ’ 3 S—<^p КАБ ‘ЦБ’ 2 S^Y>э—эх.

Нууцалж үл болох мэдээллийн хүрээг доорхи байдлаар заасан нь Төрийн нууцын тухай хуультай харьцуулахад Байгууллагын нууцын тухай хуулийн давуу тал юм. Энэ нь сэтгүүл зүйн үйл ажиллагаанд таатай нөхцөл бүрдүүлж байгаа юм.

Байгууллага дор дурдсан мэдээллийг нууцалж болохгүй: 1/ тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл; 2/ тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл; 3/ гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл

3[^]Б<— “^h’ —sh’ ~> ^Б >— ‘ЦБ’ 6 S—<^p КАБ ‘

Гэхдээ дээрх маягийн зүйл заалт заавал бүх хуульд байх шаардлагатай гэж ойлговол буруу юм. Учир нь ардчиллын ёс, зарчмаар “бүх мэдээлэл нээлттэй байна, зарим мэдээллийг гагцхүү хуулиар, үндэслэлтэй хязгаарлаж болно” эсвэл “хязгаарласнаас бусад бүх мэдээлэл нээлттэй байна” гэдгийг бид ойлгож хэвших ёстой.

Тэгэхээр нууцалж болохгүй мэдээлэл гэж хуульд заах нь мэдээлэл хаалттай байдаг, өнгөрсөн дэглэм, захиргаадах соёлын үлдэгдэл юм.



Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд олон улсын донор байгууллага, төрийн бус байгууллагын лобби, иргэний хөдөлгөөний шахалтаар мэдээллийг нээлттэй болгох чиг хандлага манайд бий болж байна. Тухайлбал, төсвийн ил тод байдал, олборлох салбарын нээлттэй байдал, төрийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах, эрх мэдэлтний хөрөнгө орлогын мэдүүлгийг нээлттэй болгох гэх мэтээр сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх алхмууд хийгдэж байна.

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ДОТООДЫН ЯМАР САЛБАР ХУУЛИУДААР ЗОХИЦУУЛСАН БАЙДАГ ВЭ?

Өнөөдрийн байдлаар манайд 360 орчим хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас мэдээлэл ил тод, нээлттэй байхтай холбоотой 120 гаруй хууль байна. Эдгээр хуулийн зохих зүйл заалтуудыг сэтгүүлч бодит амьдрал дээр хэрэглэх чадвартай байх нь нийгмийн ухамсар, төлөвшилд эерэг нөлөө үзүүлнэ.

Ялангуяа 2006 оны долоодугаар сарын 06-ны өдөр батлагдан гарсан Авлигын эсрэг хууль иргэдэд мэдээллийн эрх чөлөөг бодитойгоор эдлэх, төрийн мэдээллийг нээлттэй болгох, төрийн байгууллага, эрх мэдэлтэн, албан тушаалтны үйл ажиллагааг ил тод болгох, тайлагнах чадварыг дээшлүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр хийсэн чухал алхмын нэг юм.

Олон нийтийн мэдээлэл олж авах эрхийг янз бүрийн арга хэлбэрээр хангаж, баталгаажуулж болно. Эрх зүйн хэм хэмжээг зохицуулж байгаа салбараар нь, гүйцэтгэж буй чиг үүргээр нь, зохицуулалтын аргаар нь гэх мэтээр ангилж болдог. Дээр дурдсан 120 хуульд заасан зохицуулалт хэм хэмжээг чиг үүргээр нь доорхи байдлаар ангилж болохоор байна.

1. Тодорхой мэдээллийг олон нийтэд заавал хүргэх үүрэг хүлээлгэсэн хэм хэмжээ,
2. Тодорхой мэдээллийг олон нийтэд заавал хүргэх үүрэг хүлээлгээгүй боловч нээлттэй байлгах үүрэг хүлээлгэсэн хэм хэмжээ,
3. Олон нийтийн эрх, ашиг сонирхолтой холбоотой буюу түүнийг ямар нэг хэлбэрээр зөрчиж байгаа тухай мэдээллийг хянан шалгаж хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтанд заавал мэдэгдэх үүргийг тодорхой субъектүүдэд ногдуулсан хэм хэмжээ,
4. Олон нийтэд мэдээлэл хүргэх үүргээ биелүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр заасан хэм хэмжээ.

Дээрх ангиллын дагуу олон нийтийн мэдээлэл олж авах эрхтэй холбоотой хэм хэмжээнүүдийг дэлгэрэнгүйгээр судлая. Үүний тулд өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зүйл заалтуудыг жишээ болгон ашиглах нь зүйтэй болно.

1. Тодорхой мэдээллийг олон нийтэд заавал хүргэх үүрэг хүлээлгэсэн хэм хэмжээ.

Энэ төрөлд хамаарах хэм хэмжээ нь ямар нэг мэдээллийг иргэд заавал мэдэх ёстой тул сонин хэвлэлээр болон мэдээллийн бусад боломжтой хэлбэрээр түгээх үүргийг төрд оногдуулсан хуулийн заалтууд хамаарна. Ийм хуулийн заалтууд нь ихэвчлэн "... сонинд нийтлэнэ, ...цахим сүлжээнд байрлуулна, ...нийтэд мэдээнэ..." гэх зэрэг утгатай зохицуулалтууд хийгдсэн байдаг.

Энэ нь төрийн байгууллагын ил тод байдлыг хангах, иргэдэд тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааны тухай бодитой мэдээлэлтэй байх, мөн тухайн байгууллагатай холбоотой аливаа шударга бус үйл ажиллагааны талаарх элдвийн хардалт сэрдэлтийг байхгүй болгох гэх мэтийн маш олон эерэг үр дүнг бий болгох ач холбогдолтой хэм хэмжээнүүд юм.

Ямар хуулийн заалтууд байдаг талаар доорхи жишээг авсан болно.



Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 1 - 4 дэх хэсэгт “Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх” гэж заан энэ үүргийг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд Төрийн байгууллагаас хэрэгжүүлэх нийтлэг үүрэг хэмээн заасан байна.

2. Тодорхой мэдээллийг олон нийтэд заавал хүргэх үүрэг хүлээлгээгүй боловч нээлттэй байлгах үүрэг хүлээлгэсэн хэм хэмжээ.

Энэ төрөлд хамаарах хуулийн заалтууд нь дээрх ангилалд орсон хуулийн заалтуудаас ялгаатай нь мэдээллийг олон нийтэд заавал хүргэх идэвхитэй үүргийг албан тушаалтнуудад хүлээлгэдэггүй. Өөрөөр хэлбэл ямар нэг сонин хэвлэлд нийтлэх гэх мэтийн үүрэг хүлээлгэдэггүй. Ийм заалтууд нь ихэвчлэн “... ил тод байна, ...нээлттэй байлгана, ...нээлттэй байна” гэх зэрэг хэлбэрээр илэрдэг. Гэхдээ ямар нэг мэдээлэл авахыг хүссэн хэн ч чөлөөтэй авах боломжийг хангасан зүйл заалтуудыг, мөн мэдээллийн эрх чөлөөний үндсэн зарчим болох нууцад хамаарахаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх ёстой гэсэн зарчмын дагуу төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад бүх мэдээлэл сонирхогч этгээдийн өмнө нээлттэй байх ёстой. Энэ нь ардчилсан нийгэм дэх хүний эрхийн ойлголттой салшгүй холбоотой бөгөөд хэрвээ манай улсад энэ зарчим бүрэн гүйцэт хэрэгжиж чадахгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт заасан “Монголын ард түмэн бид эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэсэн заалттай шууд зөрчилдөнө. Учир нь мэдээллийн эрх чөлөө, ил тод байдал, тунгалаг төр бол ардчилсан нийгмийн нэгэн шалгуур үзүүлэлт нь болж байдаг билээ.

Одоо энэ төрөлд хамаарах хэм хэмжээний зарим жишээг иш татан үзье. Үүнд: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 1-2-т “Тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх”, 6 дугаар зүйлийн 1-3-т “Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах” гэх мэтийн заалтууд байна.

Гэхдээ зөвхөн эдгээртэй ижил загвартай хэм хэмжээг гэж ойлгох нь буруу. Дээр тайлбарласны дагуу ямар нэг нууцад хамаарахаас бусад мэдээлэл нь бүгд нээлттэй байх ёстой гэсэн зарчмын дагуу бүх мэдээлэл нээлттэй байх ёстой гэж ойлгох нь зүйтэй.

3. Олон нийтийн эрх, ашиг сонирхолтой холбоотой буюу түүнийг ямар нэг хэлбэрээр зөрчиж байгаа тухай мэдээллийг хянан шалгаж хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтанд заавал мэдэгдэх үүргийг тодорхой субъектүүдэд ногдуулсан хэм хэмжээ.

Энэ хэм хэмжээнд хамаарах тодорхой этгээдүүдийг нэр заан заавал гүйцэтгэх үүрэг хүлээлгэсэн байдаг.

Жишээ нь: Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Дараах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаархи мэдээллийг нэн даруй Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй.

- **шүүгч,**
- **прокурор,**
- **цагдаа, тагнуулын байгууллагын албан тушаалтан,**
- **төрийн аудитын болон мэргэжлийн хяналтын байгууллагын албан тушаалтан,**
- **төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан”**

гэж заасан байна.

Гэхдээ энэ төрөлд хамаарах хэм хэмжээ нь төдийлэн олон нийтийн мэдээлэл олж авах эрхтэй холбогдохгүй тул үүгээр өндөрлөе. Харин олон нийтийн мэдээлэл олж авах үйл ажиллагаанд саад хийсэн болон олон нийтэд тодорхой мэдээллийг заавал түгээх



үүргээ биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай ангилалд орсон хэм хэмжээг дор арай дэлгэрэнгүйгээр үзье.

Олон нийтэд мэдээлэл хүргэх үүргээ биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх нь:

Энэ төрөлд хамаарах хэм хэмжээ нь бидний ангилан үзэж байгаа хэм хэмжээний 1 ба 2 дахь хэсэгт оруулсан хэм хэмжээнүүдэд аливаа төрийн байгууллага, албан тушаалтнуудад ногдуулсан иргэдэд мэдээлэл заавал хүргэх үүрэг, мөн мэдээллийг иргэдэд нээлттэй байлгах үүргээ үл биелүүлсэн этгээдүүдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх тухай заалтуудыг хамруулан ойлгож болно. Энэ нь дээрх үүргийг заавал биелүүлэх үүргийг идэвхжүүлсэн хөшүүргийн механизм болдог хэм хэмжээ юм. Энд доорхи заалтыг жишээ болгон авч үзье. Үүнд: Агаарын тухай хуулийн 20 дугаар зүйлд “Шүүгч, байгаль орчны буюу эрүүл ахуйн байцаагч агаарын тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

- агаарын чанарт нөлөөлж буй өөрийн үйл ажиллагааны тухай болон озоны давхаргын төлөв байдалд хортой нөлөөлөх бодисын импорт, үйлдвэрлэл, агаарын чанарын тухай мэдээг тогтоосон хугацаанд мэдээлээгүй буюу зориуд буруу мэдээлсэн... аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-75000 төгрөгөөр торгох” гэж заасан байна.

Энэ төрөлд үүнээс гадна худлаа ташаа мэдээлэл түгээсэн албан тушаалтанд мөн хариуцлага хүлээлгэх тухай хэм хэмжээнүүд байдаг. Үүнд: Банкны тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1-8 дахь хэсэгт “Банкны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны хянан шалгагч дараахь хариуцлага ногдуулна:

- нийтлүүлсэн тайлан мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол тухайн банк буюу уг тайлан мэдээллийг нийтлүүлэх үед ажиллаж байсан гүйцэтгэх захирлыг 250000 хүртэл төгрөгөөр торгох” гэж заасан.

Энэ төрөлд хамаарах хэм хэмжээ нь Монгол Улсын эрх зүйн тогтолцооны дотор маш чухал байр суурь эзэлж байгаа боловч зарим талаар маш хангалтгүй дутуу зохицуулсан байдаг. Энэ бол хуулийн хийдэл юм. Одоо чухам ямар зохицуулалт дутуу байгаа талаар тодруулъя. Үүнд олон нийтийн эрх ашигтай холбоотой мэдээлэл олж авах эрхээ хэрэгжүүлэхэд саад болж байгаа этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан хэм хэмжээ бараг байхгүй байна. Өөрөөр хэлбэл та аль нэг төрийн байгууллагаас ямар нэг мэдээлэл авахыг хүсэхэд таны өмнө нээлттэй байх ёстой мэдээллийг өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан хариу өгч магадгүй юм. Жишээ нь “энэ мэдээлэл чинь нууцад хамаарах тул өгөх боломжгүй” гэж магадгүй. Гэхдээ чухам үнэхээр ямар нэг нууцад хамаарч байгаа үгүйг нь та холбогдох хууль тогтоомж, шийдвэрээс нь лавлаж харахад илүүдэхгүй. Хэрвээ тухайн мэдээлэл уг албан тушаалтны хэлснээр нууцад хамаарсан гэдэг нь худлаа байвал та уг албан тушаалтанд мэдээлэл авахад саад хийсэн гэсэн үндэслэлээр хариуцлага ногдуулахаар дээд шатны байгууллага, албан тушаалтанд болон шүүхэд хандан гомдол гаргах боломжтой байхаар хуульчилсан байх ёстой байтал, хуулинд тийм боломжийг хангасан зохицуулалт бараг байхгүй байна.

МЭДЭЭЛЭЛ АВАХ МИНИЙ ЭРХ ЗӨРЧИГДВӨЛ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БИЙ ЮУ?

Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн эрх чөлөөг Үндсэн Хуулиас гадна “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль” (1998), “Олон нийтийн радио, телевизийн тухай хууль” (2005)-иар баталгаажуулсан байдаг. Үүнээс гадна сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан чухал заалт 2001 онд батлагдсан Эрүүгийн хуулийн “Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх” гэсэн 139-р зүйл юм.

“Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд түгээх болон түгээлгэхгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол...”

ЭрАА<ЦТ>’>—‘ЦТ’ 139 СА<ээр КАТ‘ЦТ’ ’э< Дэ> >э—<

Өнгөц харвал энэ заалт мэдээлэл олж авахтай төдийлэн холбоогүй санагдаж болох юм. Гэхдээ та бол сэтгүүлч. Уэбстрийн толь бичигт тодорхойлсноор мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа юм. Мэдээлэл цуглуулах нь угтаа мэдээлэл хайх, олж авах үйл явц билээ. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн хүндрэл учирдаг. Ялангуяа төрийн эрх мэдэлтэн, албан тушаалтан, албан хаагчийн эсэргүүцэлтэй байнга тулгардаг. Үгүйдээ төрийн байгууллагад нэвтрэх, хурал цуглаанаас нь хөөгдөх, ярилцлага өгөхгүй цааргалах нь бараг ердийн. Тэгэхээр тэд таны мэдээлэл хайх, олж авах мэргэжлийн үйл ажиллагаанд саад болж байна. Ингэж саад учруулахын шалтгаан нь гол төлөв “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд түгээх болон түгээлгэхгүй байх”-тай холбоотой байдаг.

Энэ нь Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлийн объектив талын шаардлагыг хангаж байгаа юм. Танд саад хийж байгаа тухайн этгээдийн санаа, зорилго юунд чиглэгдсэн нь анхаарах нэг чухал зүйл юм. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг мөн үү, биш үү гэдгийг тогтоохын тулд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг мэддэг байх хэрэгтэй.

Гэмт хэргийн бүрэлдэхүүн нь объект, субъект, объектив тал, субъектив тал гэсэн дөрвөн элементээс бүрддэг. Эдгээрийг товчхон тайлбарлавал гэмт хэргийн бүрэлдэхүүний объект гэдэг нь гэмт халдлагад өртөж хохирсон нийгмийн харилцаа, ашиг сонирхол, гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект гэдэгт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг, гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал гэдэгт үйлдэл, эс үйлдэхүй субъектив тал гэдэгт гэмт хэрэгтэн этгээд гэмт хэрэг үйлдэж байх үеийн сэтгэл зүйн хандлагыг хэлдэг.

Субъектив талыг өөрөөр гэм буруугийн хэлбэр гэж нэрлэдэг. Гэм буруугийн хэлбэр нь санаатай, болгоомжгүй гэсэн хоёр хэлбэртэй. Тэгвэл Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйл нь гэм буруугийн санаатай хэлбэрийг шаарддаг. Өөрөөр хэлбэл танд мэдээлэл өгөхгүй байх нь түүнд өөрт нь болон өөр хэн нэгэнд ашигтай, хэрвээ та тухайн мэдээллийг аваад бусдад тарааснаар тэр этгээдийн ашиг сонирхолд хохирол учрах тул уг мэдээллийг өгөхгүй байгаа үйлдлийг “хүсэж үйлдсэн” байдаг.

Энэ зүйл заалтыг ашиглах нь таны эрхийг хамгаалах бодит боломж. Харамсалтай нь, өнөөгийн байдлаар Эрүүгийн хуулийн энэ заалтыг ашиглаж, эрх ашгаа хамгаалахыг оролдсон сэтгүүлч тун ховор байна.

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ТУСГАЙЛСАН ХУУЛИАР ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ЮУ?

Тийм ээ, шаардлагатай. Дэлхийн олон улс орон мэдээллийн эрх чөлөөг Үндсэн хуулиараа баталгаажуулан, уг эрхээ эдлэх бодит механизмыг хангаж чадахуйц практик ач холбогдолтой бие даасан хуулиудыг батлан гаргасан байна.

Үндсэн Хуулиар таны эрхийг тунхаглан баталгаажуулсан бол Мэдээллийн эрх чөлөөний хуулиар таны амьдрал дээр мэдээлэл олж авах зохицуулалтыг хийнэ. Төрөөс мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан бие даасан хуультай байх нь тухайн эрхийг хүндэтгэн үзэх, зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд мэдээллийн эрх чөлөөний хуулийн ашиг тусыг ойлгож ухаарсаны үндсэн дээр ийм хууль тогтоомж батлах хөдөлгөөн дэлхий даяар өрнөж байна. Одоогоор дэлхийн 60 -аад орон иргэдийнхээ мэдээлэл олж авах эрхийг хуульчлан хэрэгжүүлж байгаагийн 40 нь 1992 оноос хойш, 20 нь 2000 - 2003 онд, үлдсэн нь түүнээс хойш батлагджээ. Ялангуяа манайхтай ижил ардчиллын шилжилтийн үедээ яваа Болгар, Чех, Словак, Албани, Гүрж, Эстон, Латви, Кыргыз гээд бараг ихэнх орон аль хэдийн ийм хуультай болсон байна. ОХУ “Мэдээлэл, мэдээжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлын



тухай хууль” - даа албан тушаалтнуудыг иргэдэд мэдээлэл өгөх үүрэг ногдуулсан байна.

Манай өмнөд хөрш коммунист Хятад улс хүртэл авилгатай тэмцэх ажлынхаа хүрээнд ийм хуультай болжээ. Өндөр албан тушаалтнууд нууц амрагийнхаа нэрийг хүртэл ил тод хэлэх хэрэгтэй.

Улс орнууд ийм хууль тогтоомжийг батлахдаа олон улсын хэм хэмжээнд аль болох нийцүүлэхийг эрмэлзэж байна. Йоханнесбургийн олон улсын зарчмыг дор дурдав.

- Төрийн байгууллагуудад хадгалагдаж буй мэдээлэл нь олж авахад хялбар, нээлттэй байх ёстой бөгөөд дээд зэргээр нээлттэй байх нь хуулийн үзэл баримтлалын гол цөм байна.
- Төрийн байгууллагууд нь чухал мэдээллийг хэвлэн нийтэлж байх үүрэгтэй байна
- Төрийн байгууллагууд нээлттэй засаглалыг идэвхийлэн дэмжих ёстой.
- Мэдээллийн хязгаарлалт нь маш ойлгомжтой, нарийн тодорхойлогдсон байна. Засгийн газар, түүний байгууллагууд өөрийн буруутай үйлдлийг нуун дарагдуулахын тулд иргэдийн мэдээлэл олж авахад саад тотгор болох зүйлийг хуульчилж болохгүй. Гагцхүү нийгэмд ноцтой хор хохирол учруулах нөхцөлд л мэдээлэл өгөхөөс татгалзаж болно.
- Иргэдийн мэдээлэл олж авах үйлдлийг хөнгөвчилсөн байх ёстой. Төрийн байгууллагууд иргэдийн мэдээлэл олж авах эрхийг бүрэн хангаж чадахуйц дотоод тогтолцоог бий болгох шаардлагатай
- Хувь хүмүүс мэдээлэл олж авахын тулд өндөр төлбөр төлөх ёсгүй
- Төрийн байгууллагын хурал, хуралдаан олон нийтэд нээлттэй байх ёстой. Хаалттай хуралдаан зохион байгуулах тухай шийдвэр олон нийтэд нээлттэй байна.
- Дээд зэргээр нээлттэй байх зарчимд харшилсан, зөрчилдсөн хууль тогтоомжийг өөрчлөн сайжруулах ёстой. Дэлхийн улс орнуудад Мэдээллийн эрх чөлөөний хууль нь мэдээлэл, нууцтай холбоотой бүх хуулийн тулгуур хууль байдаг бөгөөд бусад хуулийн заалт энэ гол хуультайгаа зөрчилдөхгүй байх зарчмыг баримталдаг байна.
- Гэм буруутай үйлдлийн тухай мэдээлэл түгээсэн иргэн - мэдээлэгчийг хамгаалах ёстой. Гэм буруутай үйлдэл гэдэгт гэмт хэрэг үйлдэх, хууль ёсны үүргээ зөрчих, шударга ёсыг хөсөрдүүлэх, авилгад өртөх, төрийн байгууллагын үйл ажиллагааг завхруулах зэргийг багтаан ойлгодог ажээ.

Лондон хот дахь 19-р зүйл байгууллага (ARTICLE 19) олон улсын хэм хэмжээ тогтоох “Олон нийтийн мэдэх эрх: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хууль тогтоомжийн зарчим”⁷ боловсруулжээ. НҮБ-ын Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний тусгай илтгэгч эдгээр зарчмыг бусад зарчмын адил өөрийн 2000 онд тавьсан илтгэлдээ дэмжсэн⁸.

Эдгээр зарчмыг дараахь байдлаар дүгнэн хэлж болно:

1. Мэдээлэл аль болох нээлттэй байна: Хууль тогтоомжид мэдээллийг боломжийн хэрээр дээд зэргээр нээлттэй болгох тухай заалт оруулах.

2. Нийтлэх үүрэг: Төрийн байгууллага нь өөрийн санаачилгаар үндсэн мэдээллээ нийтлэх үүрэгтэй.

3. Нээлттэй төрд дэмжлэг үзүүлэх: Төрийн байгууллага нь нээлттэй төрд идэвхтэй дэмжлэг үзүүлнэ.

4. Хамаарахгүй зүйлийн хүрээг хязгаарлах: Үл хамаарах зарчмыг явцуу хүрээнд төрийн “ашиг сонирхол”-д “хохирол” учруулахгүй байх үүднээс тодорхойлох

⁷ Лондон 1999, 6 дугаар сар

⁸ Өөрийн гэсэн үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг дэмжих болон хамгаалах тухай Тусгай илтгэгчийн илтгэл DOC. E/CN.4/2000/63, 2000 оны 1 дүгээр сарын 18, параграф 43

5. Мэдээлэл олж мэдэх процесст дэмжлэг үзүүлэх: Мэдээлэл авах хүсэлт шаардлагыг аль болох шуурхай, шударга биелүүлэх, мэдээлэл олгохоос татгалзсан тохиолдолд энэ шийдвэрийн эсрэг хараат бус байгууллагад хандан давж заалдах эрхээр хангах.

6. Зардал: Хувь хүний мэдээлэл хүсэх эрхийг хэт өндөр үнэ тогтоож хязгаарлах ёсгүй.

7. Нээлттэй хурал: төрийн байгууллагын хурал нийтэд нээлттэй байх ёстой.

8. Мэдээллийг нээлттэй болгох жишиг тогтоох: Мэдээлэл боломжийн хирээр дээд зэргээр нээлттэй байх зарчимд үл нийцэх хууль тогтоомжийг өөрчлөх.

9. Шүгэлдэгчийг хамгаалах: Шүгэлдэгч буюу болж бүтэхгүй зүйлийн талаар мэдээлсэн этгээдийг хамгаалах ёстой.

Мэдээллийн эрх чөлөөний үзэл санаа, зарчим, олон улсын хэм хэмжээг Монголд түгээн дэлгэрүүлэх, хуулийн төсөл боловсруулах, улс төрчдийг лоббидох өргөн цар хүрээтэй ажлыг “Глоб Интернэшнл” ТББ Соросын сан, Австралийн олон улсын тусламжийн агентлаг, АНУ-ын Элчин сайдын яамны тусламжтайгаар 2001 онд эхэлсэн билээ.

2007 оны 5-р сарын 2-ны өдөр УИХ-ын гишүүн Сү.Батболд, Э.Бат-Үүл, Ц.Мөнх-Оргил, С.Оюун нар “Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан юм.

Монгол улс **“МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХУУЛЬ”**-тай болоход сэтгүүлч та хамгийн бодитой хувь нэмэр оруулах боломжтой. Хэвлэл мэдээллийн лобби хамгийн үр дүнтэй байдгийг олон туршлага гэрчилнэ.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдан гарвал доорхи асуудлуудыг нарийвчлан зохицуулах ёстой. Үүнд:

- Хязгаарласнаас бусад /нууцад хамаарахаас бусад/ бүх мэдээлэл нээлттэй байх ёстой,
- Нээлттэй мэдээллийг авахыг хүссэн хэнд ч гэсэн заавал өгөх үүргийг холбогдох субъектүүдэд оногдуулах,
- Зарим олон нийт заавал мэдэх ёстой мэдээллийг цаг хугацаанд нь түргэн шуурхай нийтэд хүргэж байх,
- Төрөөс мэдээлэл авахад ямар арга хэлбэрээр авч болохыг зохицуулах,
- Төрөөс мэдээлэл авахад гарах зардлыг хэрхэн зохицуулах,
- Нээлттэй мэдээллийг авахыг хүссэн хүний хүсэлтийг хангаагүй буюу зөрчсөн этгээдэд хариуцлага оногдуулах,
- Нийтэд заавал мэдээлэл хүргэх үүргээ биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх гэх мэт асуудлуудыг нарийвчлан зохицуулах боломжтойгоороо өндөр ач холбогдолтой юм.



СЭТГҮҮЛЧ ТАНД ЗӨВЛӨХ НЬ

1. Төрийн байгууллага, эрх мэдэлтэн, албан хаагчтай харилцахдаа сэтгүүлч эн тэргүүнд тэдгээрт бус, олон нийтэд үйлчилдэг болохоо ямагт санаж яв
2. Аливаа асуудлаар төрийн байгууллагад хандахын өмнө өөрөө мэдээлэлтэй бол. Үүнд байгууллагын вэб сайт, танилцуулга, үйл ажиллагааны тайлан гэх мэт урьд өмнө нийтэд ил болсон мэдээллийг ашиглаж болно
3. Төрийн байгууллагаас мэдээлэл авахын тулд хэнд нь хэрхэн хандахаа урьдчилан судал
4. Төрийн байгууллагад хадгалагдаж буй мэдээлэл нь сэтгүүлчийн цорын ганц эх сурвалж бус, харин нэг л хэлбэр болохыг үргэлж санагтун
5. Төрийн байгууллагаас авсан мэдээлэл заримдаа хуудуутай, ташаа байдаг тул өөр эх сурвалжаас баталгаажуул
6. Төрийн байгууллагын судалгааны мэдээллийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гэх мэт бусад байгууллагынхтай харьцуулж шалга
7. Төрийн удирдах дээд байгууллагын баталсан хуулийн эерэг зүйл заалт бол таны өмнөө барих жад тул байнга, үр дүнтэй ашигла
8. Хуулийн зүйл заалт хэрэгжихгүй байгаа нь төрийн байгууллагын алдаа дутагдал тул шүүмжлэлийн бай гэдгийг санагтун
9. Төрийн байгууллагаас зохион байгуулж буй ёслолын хурал цуглаан, тайлангийн хурлын үеэр хийсэн мэдэгдэлд болгоомжтой ханд. Тэнд гол төлөв өөрийгөө магтах, дөвийлгөх өнгө аяс давамгайлдаг тул мэдээлэл хэтэрхий туйлширсан байж болзошгүй
10. Төрийн эрх мэдэлтэн, албан тушаалтнаас ярилцлага авахдаа асуусан зүйлээс тань бултах боломж бүү олго
11. Төрийн байгууллагын эрх мэдэлтэн, албан тушаалтан, албан хаагчийн сайхан үг, амлалтад хууртахгүйг хичээ. Тэдний өгсөн мэдээллийг бичиг баримтын эх сурвалжаар нотолгоожуулахыг хичээ
12. Сэтгүүлчийн эрх зорилго, үүрэг бол төрийн байгууллагаас олсон мэдээллийг тэр чигээр нь олон нийтэд хүргэн зуучлахад бус харин эрх мэдлийг хянахад байдгийг эцэст нь дахин сануулья.

МЭДЭЭЛЭЛ НЭЭЛТТЭЙ БАЙХ ХЭМ ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛСОН ХУУЛИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫН ТҮҮВЭР

1. Олон нийтэд мэдээлэл заавал хүргэх үүрэг хүлээлгэсэн хэм хэмжээ

1. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ

2006 "н 07 – рн" 06 S p
с рЦБ' "рS". о "ф" "р" > "

ХОЁРДУГААР БҮЛЭГ

6 дугаар зүйл. Авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

- 6.1.4. төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх;
- 6.1.7. төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;
- 6.5.1. төрийн бус байгууллага гишүүнийхээ ёс зүйн дүрмийг баталж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа ил тод мэдээлж байх;

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах

14 дүгээр зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх

- 14.1. Дараахь албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хэвлэн нийтлэх ба цахим мэдээллийн сүлжээнд байрлуулна:
 - 14.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч;
 - 14.1.2. Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;
 - 14.1.3. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, дэд сайд;
 - 14.1.4. Үндсэн хуулийн цэцийн дарга, ний орлогч, гишүүн;
 - 14.1.5. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга;
 - 14.1.6. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;
 - 14.1.7. Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч;
 - 14.1.8. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
 - 14.1.9. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга;
 - 14.1.10. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
 - 14.1.11. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
 - 14.1.12. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга;
 - 14.1.13. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;
 - 14.1.14. Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;
 - 14.1.15. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;

- 14.1.16. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;
 - 14.1.17. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;
 - 14.1.18. Ерөнхий аудитор, түүний орлогч;
 - 14.1.19. Засгийн газрын агентлагийн дарга;
 - 14.1.20. аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга;
 - 14.1.21. аймаг, нийслэлийн Засаг дарга.
- 14.2. Энэ хуулийн 14.1-д зааснаас бусад этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байна.
- 14.3. Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хөрөнгө, орлогын сүүлийн 5 жилийн мэдүүлэг Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд тавигдах ба иргэд мэдээлэл авах боломжийг хангана.
- 14.4. Иргэд бичгээр, амаар, цахим мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл авч болох бөгөөд тэдгээрт мэдээлэл өгөх журмыг Авлигатай тэмцэх газар ба-тална.
- 14.5. Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаар жил бүр олон нийтэд мэдээлнэ.
- 18.1.7. төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх.

2. АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

1999 "н 06 S—<^p — ^ph' 04- 'ЦБ S p
o'^(^):^p>”~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

14 дүгээр зүйл. Тээвэрлэлтийн ажлыг түр хугацаагаар зогсоох, хязгаарлах

- 14.1. Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, гал түймэр зэрэг гэнэтийн аюул тохиолдсон нөхцөлд тээвэрлэлтийн ажлыг түр хугацаагаар зогсоох буюу хязгаарлах шийдвэрийг дараахь эрх бүхий албан тушаалтан гаргаж нийтэд мэдээлнэ:

3. АГААРЫН ТУХАЙ

1995 "н 3 S—<^p — ^ph' 31- 'ЦБ S p
o'^(^):^p>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АГААРЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН УДИРДЛАГА, ЧАНАРЫН ХЯНАЛТ, МЭДЭЭЛЭЛ

6 дугаар зүйл. Агаарын чанарын тухай мэдээлэл

3. Мэргэжлийн алба нь агаарын бохирдол, физикийн хортой нөлөөллийн түвшин стандартад заасан хэм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд холбогдох байгууллага, олон нийтэд шуурхай мэдээлнэ.

4. АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

1996 "н 8 S—<^p — ^ph' 27- "н S p
o'^(^):^p>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Сонгууль зарлах, сонгуулийн хэсэг байгуулах

5 дугаар зүйл. Сонгууль зарлах

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг санал авах өдрөөс 21-ээс доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана.

/Энэ хэсэгт 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

6 дугаар зүйл. Сонгуулийн хэсэг, түүнийг байгуулах

Сонгогчдын санал авч тоолох зорилгоор сонгуулийн хэсгийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 16-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, хэсгийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг зарлана.

/Энэ зүйлд 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Сонгууль эрхлэн явуулах байгууллага, түүний бүрэн эрх

9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, түүний бүрэн эрх

1. Аймаг, нийслэлийн хэмжээнд сонгууль бэлтгэн явуулах ажлыг зохион байгуулах, санал хураалтын дүнг нэгтгэн гаргах зорилгоор тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 18-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, нийтэд мэдээлнэ. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүний тоог ажлын хэмжээ, намын төлөөллийг харгалзан тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

/Энэ хэсэгт 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

10 дугаар зүйл. Сум дүүргийн сонгуулийн хороо, түүний бүрэн эрх

1. Сум, дүүргийн хэмжээнд сонгууль бэлтгэн явуулах ажлыг зохион байгуулах, санал хураалтын дүнг нэгтгэн гаргах зорилгоор тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 16-аас доошгүй хоногийн өмнө сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, нийтэд мэдээлнэ. Сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүний тоог ажлын хэмжээ, намын төлөөллийг харгалзан тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

/Энэ хэсэгт 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

11 дүгээр зүйл. Сонгуулийн хэсгийн хороо, түүний бүрэн эрх

1. Сонгуулийн хэсгийн хороог санал авах өдрөөс 16-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид байгуулж, нийтэд мэдээлнэ. Сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчдын тоо, ажлын хэмжээг харгалзан тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

/Энэ хэсэгт 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

4. Сонгуулийн хэсгийн хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ сонгуулийн хэсгийн хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

ТАВДУГААР БҮЛЭГ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх

19 дүгээр зүйл. Нэр дэвшигч, тэдгээрийн жагсаалт

2. Нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг сонгуулийн хэсгийн хорооны байранд байрлуулан, орон нутгийн сонин хэвлэлд нийтэлж нийтэд танилцуулна.

20 дугаар зүйл. Нэр дэвшигчийг бүртгэх

2. Сонгуулийн хороод нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэр гаргах бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хороо энэ шийдвэрээ аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.



Нэр дэвшигчийг бүртгэх хугацаа дууссанаас хойш сум, дүүргийн сонгуулийн хороо ажлын 3 өдрийн дотор, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо ажлын 6 өдрийн дотор нийт нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээгээр нэгтгэн гаргаж, нийтэд мэдээлнэ.

21 дүгээр зүйл. Нэр дэвшүүлсэн шийдвэрийг хүчингүй болгох, нэр дэвшигч татгалзах

1. Нэр дэвшигч өөрөө татгалзах буюу нам, эвсэл нь нэр дэвшүүлэгчээ татан гаргах, түүний оронд өөр хүний нэр дэвшүүлэх эрхтэй. Нэр дэвшигч буюу нам, эвсэл энэ тухай шийдвэрээ аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд нэн даруй мэдэгдэнэ. Нэр дэвшсэнийг хүчингүйд тооцсон тухай аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэр, нэр дэвшигч өөрөө татгалзсан буюу, эсхүл нам, эвсэл өөрийн нэр дэвшигчийг татан гаргасан тухай аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах, дүнг гаргах, Хурлын Төлөөлөгчийг бүртгэх

26 дугаар зүйл. Санал авах байр, хугацаа

1. Сонгогчдын саналыг санал авах өдөр 7. 00 цагаас оройн 22. 00 цаг хүртэл санал авах байранд авна. Сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг сонгуулийн хэсгийн хороо санал авах өдөр хүртэл 10 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.

31 дүгээр зүйл. Санал тоолох

1. Санал тоолох ажлыг санал авахаар товлосон өдрийн оройн 22. 00 цагт эхэлж, ил тод, нээлттэй явуулна. Санал тоолоход ажиглагчид, сонгогчдын болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид байлцаж болно.

5. АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ

1995 "н 10 S—<^p—^ph' 19- 'ЦБ S p
o'^^:~^~^p>'~

8 дугаар зүйл. Хэсгийн хорооны бүрэн эрх

Хэсгийн хороо санал асуулга явуулах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 1/ хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг иргэдэд мэдээлэх;

13 дугаар зүйл. Санал асуулга товлон зарлах

3. Санал асуулга явуулах тухай шийдвэрийг гарсан өдрөөс нь хойш нэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

6. АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

ҮЦ'эЦЦ'—э' ''Бp— — <^
2000 "н 01 SA<эep—^ph' 28- 'н S p
o'^^:~^~^p>'~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Архидан согтуурахтай хийх тэмцэл

10 дугаар зүйл. Стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааг нийтэд мэдээлэх

- 10.1. Эрх бүхий байгууллагын шалгалт, шинжилгээгээр хүний амь нас, эрүүл мэндэд хортой болох нь тогтоогдсон, стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны хор хөнөөлийн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд шуурхай зарлан мэдэгдэнэ.

47.7. Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн нэрийг тухайн бүтээгдэхүүний нэр төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлана

48 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах

48.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах

49 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх

49.11. Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл шилжүүлснийг бүртгэсэн талаар мэргэжлийн хяналтын алба, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

50 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг шилжүүлэх

50.6. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 50.5-д заасны дагуу бүртгэл хийсэн тухайгаа мөн хуулийн 49.11-д заасан байгууллагуудад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл дуусгавар болох

54 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгөх

54.5. Төрийн захиргааны байгууллага нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан авсан тухай зохих байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

55 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан өгөх

55.6. Төрийн захиргааны байгууллага тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан авсан тухай зохих байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

56 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг цуцлах

56.7. Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалсан бол мэргэжлийн хяналтын байгууллагад, ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан бол татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус мэдэгдэж өдөр тутмын сонинд нийтэлнэ.

9. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ

2000 "н 05 S—<^p —^ph' 05- н S p
o (^^^;^p>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Аялал жуулчлалын байгууллага

10.1.3. нийтийн гэрээний нөхцөлөө дараагийн хуанлийн жил эхлэхээс 3-аас доошгүй сарын өмнө зарлах;

13.1.3. Монгол Улсын нийгэм эдийн засаг, төрийн байгуулал, байгаль, түүх, соёл, ард түмний зан заншлын талаар жуулчдад бодит мэдээлэл өгөх, улс, хувь хүн, байгууллагын нууцад хамаарах мэдээллийн нууцыг задруулахгүй байх;

10. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

2002 "н 12 S—<^p—^ph' 12-н S p
o'^(^)^&^^^p>”~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Өөрийн хөрөнгө, санхүүгийн тайлан

15 дугаар зүйл. Санхүүгийн тайлан, түүнийг нийтэд мэдээлэх

15.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.

18 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагыг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл

18.3. Монголбанк баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай холбогдох асуудлыг шийдвэрлэж нийтэд мэдээлнэ.

11. БАНКНЫ ТУХАЙ

1996 "н 9 SA<ээр—^ph' 3-н S p
o'^(^)^&^^^p>”~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Банк байгуулах

24 дүгээр зүйл. Банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгох

1. Монголбанк банк байгуулах зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгож нийтэд зарлана:

ДОЛДУГААР БҮЛЭГ

Банкны эрх хүлээн авах

42 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авах ажиллагаа эхэлснийг зарлан мэдэгдэх

1. Банкны эрх хүлээн авагч томилогдсоноосоо хойш 24 цагийн дотор удирдлага, хяналт нь түүнд шилжсэн тухай зарлалыг тухайн банк, түүний салбарын байранд гаргаж, харилцагчид мэдэгдэнэ.

/Энэ хэсэгт 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

43 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авагчийн бүрэн эрх

Банкны эрх хүлээн авагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

б/ шаардлагатай гэж үзсэн мэдээллийг нийтэд мэдээлэх;

12. БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАРЗҮЙН ЗААЛТЫН ТУХАЙ

2003 "н 05 S—<^p—^ph' 02-н S p
o'^(^)^&^^^p>”~

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

28 дугаар зүйл. Барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгох, хүчингүй болсонд тооцох

28.6. Барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгосон, эсхүл хүчингүй болсонд тооцсон тохиолдолд оюуны өмчийн байгууллага нь барааны тэмдэг, газар зүйн



заалтын улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулж, энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтэлнэ.

13. ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ

2003 "н 06 SA—^п—^п20- ЦБ S p
o (^^)^(^p) ^

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

6 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах

6.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон гамшгаас хамгаалах алба гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүнгийн тухай хүн амд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр цаг тухайд нь үнэн зөв мэдээлнэ.

/Энэ хэсэгт 2005 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

14. ДААТГАЛЫН ТУХАЙ

(ҮЦ'эЦЦ'—э' 'Тр— (^)

2004 "н 04 SA<ээр —^п30- н S p
o (^^)^(^p) ^

ДОЛДУГААР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэл, аудит

29 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

29.5. Даатгагч энэ хуулийн 29.4-т заасан шаардлагыг хангасан санхүүгийн тайланг улирал тутам, аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлнэ.

33 дугаар зүйл. Аудит

33.3. Зохицуулах хороо энэ хуулийн 33.2-т заасан эрх бүхий аудиторын нэрсийн жагсаалт болон түүнд өөрчлөлт орсон тухай бүр даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

15. ДАЙН БҮХИЙ БАЙДЛЫН ТУХАЙ

1998 "н 1 SA<ээр —^п8- н S p
o (^^)^(^p) ^

5 дугаар зүйл. Дайн бүхий байдал зарлах

5.5. Дайн бүхий байдал зарласан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нэн даруй зарлана.

7 дугаар зүйл. Дайн бүхий байдлыг цуцлах

7.3. Дайн бүхий байдлыг цуцалсан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нэн даруй зарлана.

16. ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ

1998 "н 5 S—<^p—^ph' 21- ЦБ S p
o'^(^)^&^~^p>"~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Дайны байдал зарлах нөхцөл

5 дугаар зүйл. Дайны байдал зарлах

- 5.4. Дайны байдал зарласан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг дагаж мөрдөхөөс нь 6-аас илүүгүй цагийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг нэн даруй олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.

6 дугаар зүйл. Дайны байдлыг цуцлах

- 6.3. Дайны байдлыг цуцалсан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг нэн даруй олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.

17. ДАМПУУРЛЫН ТУХАЙ

1997 "н 11 SA<ээр—^ph' 20- н S p
o'^(^)^&^~^p>"~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Дампуурлын хэрэг үүсгэх

5 дугаар зүйл. Дампуурлын хэрэг үүсгэх

- 5.5. Хариуцагчийг төлбөрийн чадваргүй болсныг тогтоосноос хойш 7 хоногийн дотор шүүх энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ. Уг мэдээлэлд нэхэмжлэгчдийн анхны хурал хийх он, сар, өдөр, газар, нэхэмжлэгчдээс нэхэмжлэл гаргах журам, хугацаа, нэхэмжлэлийг хуульд заасан хугацаанд гаргаагүйгээс үүсэх үр дагавар зэргийг заана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хариуцагчийг татан буулгах

33 дугаар зүйл. Хариуцагчийг татан буулгах

- 33.2. Хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 хоногийн дотор шүүх энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

18. ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ

2002 "н 5—^ph' 30- н S p
o'^(^)^&^~^p>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Зар сурталчилгаанд тавих тусгай шаардлага

13 дугаар зүйл. Эрүүл мэндийн салбар дахь зар сурталчилгаа

- 13.3. Эмийг сурталчлахдаа тэдгээрийг хэрэглэх заавартай танилцахыг заавал сануулна.

17 дугаар зүйл. Банк, санхүү, хөрөнгө оруулалтын сан, даатгалын үйл ажиллагаа, үнэт цаасны зар сурталчилгаа

- 17.1. Банкны үйл ажиллагааны зар сурталчилгаа нь тухайн банкны төлбөрийн чадварын болон банкны хуулиар заагдсан бусад үзүүлэлтүүдэд үндэслэсэн, үнэн зөв байна. Банкны



8.1. Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

22. КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ

1999 "н 12 – пн' 16- н S p

о'^^'ф^^^п>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Газрын кадастрын харилцаа

10 дугаар зүйл. Газрын кадастр эрхлэх байгууллага, түүний чиг үүрэг

10.2.7. газрын нэгдмэл сангийн үндсэн, дэлгэрэнгүй ангилалд орж байгаа өөрчлөлт, хөдөлгөөний талаархи тайланг Засгийн газарт жил бүр гаргаж, энэ талаархи мэдээллээр нийтэд үйлчлэх;

23. КОМПАНИЙН ТУХАЙ

1999 "н 07 S—<^п – пн' 02- н S p

о'^^'ф^^^п>"~

ДОЛДУГААР БҮЛЭГ

Компани өөрийн үнэт цаасыг худалдан авах болон эргүүлэн авах

55 дугаар зүйл. Хувьцааг эргүүлэн авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам

55.5. Компани нь хувьцааг эргүүлэн авах тухай хувь нийлүүлэгчдийн шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор эргүүлэн авах эрхийн тухай мэдээлсэн мэдэгдэлд дурдсан зах зээлийн үнээр худалдан авах, эсхүл тэдгээрийн эргүүлэн авах эрхийг хэрэгжүүлэхээс татгалзсан үндэслэлээ хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ.

24. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛЬ

1993 "н 2 S—<^п – пн' 15- н S p

о'^^'ф^^^п>"~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

7 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

5. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам нэр дэвшигчийг бүртгүүлснээс хойш 5 хоногийн дотор сонгуулийн зардлын сан байгуулж банкинд данс нээж, Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдэж нийтэд зарлана. Энэ дансанд тухайн нэр дэвшигчийн өөрийн болон нэр дэвшүүлсэн намын хөрөнгө, талархан дэмжигч нам, байгууллага, иргэдээс оруулсан хандивыг төвлөрүүлж мөн дансаар дамжуулан зарцуулна.

8. Нэр дэвшүүлсэн нам болон сонгуульд хамтарч нэр дэвшүүлсэн намуудыг төлөөлөх байгууллага сонгуулийн зардлын сангийн зарцуулалтын тайланг дансны хөдөлгөөн зогсоосон өдрөөс хойш 21 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ. Сонгуулийн ерөнхий хороо уг тайланг хянан үзэж сонгууль дууссан өдрөөс хойш хоёр сарын дотор дүнг хэвлэлд нийтэлнэ.

/Энэ хэсэгт 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/



- 1/ тухайн чуулганы хугацаанд нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг 3-аас дээш удаа тасалсан гишүүний талаар хуралдаан даргалагч тухай бүр нийтэд мэдээлнэ;

29. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

/ҮЦᠡЦЦ‘-э’ ”ᠪp—‘᠘’/
2005 ””h 12—^ph’ 29-’Цᠪ S p,

o‘^^ᠴ^^^p>”~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

9 дүгээр зүйл. Сонгууль бэлтгэн явуулах ажлын ил тод байдал

- 9.1. Сонгууль бэлтгэн явуулах ажил ил тод байх бөгөөд энэ нь сонгогчдийн санал нууцаар авахад хамаарахгүй.
- 9.2. Сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан шийдвэр нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд албан ёсоор мэдээлэгдсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Сонгуулийн байгууллага, түүний зохион байгуулалт, бүрэн эрх

16 дугаар зүйл.Тойргийн хороо, түүний бүрэн эрх

- 16.1. Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө тойргийн хороог дарга, нарийн бичгийн дарга, 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ.
- 16.2. Тойргийн хороо тойргийнхоо хэмжээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 16.2.10. санал хураасан дүнгийн тухай харьяалах салбар болон хэсгийн хорооны шийдвэрийг үндэслэн тойргийн хэмжээнд сонгуулийн дүнг гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргэх, олон нийтэд мэдээлэх;

17 дугаар зүйл.Салбар хороо, түүний бүрэн эрх

- 17.1. Тойргийн хороо нь суманд, шаардлагатай бол нийслэлийн дүүрэгт салбар хороог санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тойргийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

18 дугаар зүйл.Хэсгийн хороо, түүний бүрэн эрх

- 18.1. Нийслэлд тойргийн хороо, аймагт салбар хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.
- 18.3. Хэсгийн хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 18.3.1. хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

19 дүгээр зүйл.Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт

- 19.4. Сонгуулийн хороод хуралдаанаараа дэгээ тогтоох бөгөөд түүнд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажиллах зарчим, журмыг тусгасан байна.
- 19.5. Сонгуулийн хороодын хуралдааныг нээлттэй явуулж, шийдвэрийг ил тод мэдээлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Сонгуулийн зардал

40 дүгээр зүйл. Сонгуулийн зардлын данс

- 40.1. Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшигч тус бүр дээр, түүнчлэн бие даан нэр дэвшигч нь өөрийн сонгуулийн зардлын дансыг банкинд нээлгэж, Сонгуулийн ерөнхий хороонд энэ тухай албан ёсоор мэдэгдэж, нийтэд зарлана.

42 дугаар зүйл. Сонгуулийн зардлын тайлан гаргах

- 42.7. Сонгуулийн ерөнхий хороо зардлын тайланг хянан үзэж, санал хурааж дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба хоёр зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, таван зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Санал авах, сонгуулийн дүн гаргах, Улсын Их Хурлын гишүүнийг бүртгэх

43 дугаар зүйл. Санал авах газар, хугацаа

- 43.2. Сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг хэсгийн хороо уул өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.

45 дугаар зүйл. Санал авах ажиллагаа

- 45.1. Санал авах өдрийн 07 цагт хэсгийн хорооны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөллийг байлцуулан санал авах бүх хайрцгийг нээж, шалган битүүмжилж лацдсаны дараа дараахь зүйлийг мэдээлнэ:
- 45.1.1. нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо;
 - 45.1.2. хүлээн авсан, урьдчилан санал авахад зарцуулсан, алдагдаж үрэгдсэн, утсан, үлдсэн саналын хуудасны тоо;
 - 45.1.3. урьдчилан санал өгсөн сонгогчдын тоо, түүний явцад буруу тэмдэглэл хийснээс хүчингүй болсон саналын хуудасны тоо;
 - 45.1.4. санал авах зөөврийн битүүмжилсэн хайрцгийн тоо, түүгээр санал өгөх сонгогчийн тоо, санал авах хуваарь;
 - 45.1.5. хүлээн авсан, тараасан, буруу бичсэнээс хүчингүй болсон, алдагдаж үрэгдсэн, утсан, үлдсэн, сонгогчийн үнэмлэхийн тоо.
- 45.7. Санал авах ажиллагаанд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн томилсон ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.

48 дугаар зүйл. Санал тоолох

- 48.1. Санал тоолох ажиллагааг 22 цагт эхэлж, ил тод, нээлттэй явуулна.
- 48.2. Санал тоолоход ажиглагч, хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчид байлцаж болно.

51 дүгээр зүйл. Сонгуулийн нэгдсэн дүнг гаргах, мэдээлэх

- 51.2. Сонгуулийн ерөнхий хороо нам, эвслийн авсан суудлын тоо, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдогчдийн нэрийн жагсаалтыг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор гаргаж, Монгол Улсын ерөнхийлөгчид айлтган нийтэд мэдээлнэ.

30. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

199, "h 12 S—c^p — ph' 28- h S p
o (^)z (^)p > ^"

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Олон улсын гэрээг бүртгүүлэх, хэвлэн нийтлэх, хадгалах

25 дугаар зүйл. Олон улсын гэрээг хэвлэн нийтлэх

2. Олон улсын гэрээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн тусгай эмхтгэл болгон хэвлэж байна.



40. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР ХУДАЛДАН АВАХ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ЖУРМЫН ТУХАЙ

2000 "н 04 SA<эep – ^ph' 14- 'ЦБ S p
o'^(^)'&^^^>'p>'~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Гүйцэтгэгч сонгох ажиллагааны үндсэн журам

15 дугаар зүйл. Тендерийн урилгыг зарлан мэдээлэх

- 15.1. Захиалагч тендерийн урилгыг өдөр тутмын сонин болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлнэ.
- 15.3. Төсөвт өртөг нь 1'000'000'001 төгрөгөөс дээш байх ажлын, 100'000'001 төгрөгөөс дээш байх барааны тендерийн урилгыг олон улсын хэмжээний, эсхүл олон улсын хэл дээр хэвлэгддэг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлнэ.

41. ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ

2003 "н 01 SA<эep – ^ph' 03- 'н S p
o'^(^)'&^^^>'p>'~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

5 дугаар зүйл. Хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл, журам

- 5.12. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хяналт шалгалтын байгууллага хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлнэ.

42. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ

2002 "н 06 S—<^p – ^ph' 27- 'н S p
o'^(^)'&^^^>'p>'~

ТАВДУГААР БҮЛЭГ

Төрийн албаны төв байгууллага болон төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлого

45 дугаар зүйл. Төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх журам

- 45.2. Төрийн албаны төв байгууллага нь сонгон шалгаруулж нэр дэвшүүлэхээс 21-ээс доошгүй хоногийн өмнө тухайн албан тушаалын талаар нийтэд мэдээлнэ.
- 45.4. Төрийн албаны төв байгууллага нь албан тушаалд нэр дэвшигчдийг төсвийн ерөнхийлөн захирагч буюу төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан, хэрхэн сонгосноо, нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтын хамт нийтэд мэдээлнэ.



43. УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ

Улс төрийн Намын Тухай
2005 оны 01-р сарын 28-ны
Сурвалж

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Нам байгуулах

8 дугаар зүйл. Нам үүсгэн байгуулах

8.5. Намыг үүсгэн байгуулах хурлаас нам үүсгэн байгуулсан тухай шийдвэр гарсан өдрийг тухайн нам үүсэн байгуулагдсан өдөрт тооцох бөгөөд энэ тухай нийтэд зарлан мэдээлнэ.

9 дүгээр зүйл. Намыг улсын бүртгэлд бүртгэх

9.4. Улсын дээд шүүх намыг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш энэ хуулийн 6; 9.2-9.3-т заасан зүйлийг нягтлан үзэж, ажлын 30 хоногийн дотор тухайн намыг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох бөгөөд энэ тухай нийтэд мэдээлнэ.

10 дугаар зүйл. Намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах

10.2. Улсын дээд шүүх тухайн намыг бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг энэ хуулийн 9.4-т заасан хугацаанд гаргах бөгөөд уг шийдвэрт татгалзсан үндэслэлээ тодорхой заана. Энэхүү шийдвэрийг зохих этгээдэд албан ёсоор мэдэгдэж, нийтэд мэдээлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Намын зохион байгуулалтад тавих шаардлага

15 дугаар зүйл. Намыг өөрчлөн байгуулах, нам нэрээ өөрчлөх

15.7. Бүртгэх байгууллага өөрчлөн байгуулагдах замаар үйл ажиллагаагаа зогсоосон намын гэрчилгээг хүчингүйд тооцож, уг нам улсын бүртгэлээс хасагдсаныг нийтэд мэдээлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Намын санхүүжилт

18 дугаар зүйл. Гишүүний татвар, намд өгөх хандив

18.4. Нам хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна.

20 дугаар зүйл. Намын санхүүгийн хяналт

20.3. Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.

23.2. Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, яс, үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулсан буюу шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист намын хэлбэрт шилжсэн бол Улсын дээд шүүх намыг тараах тухай шийдвэр гаргаж, уг намыг энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд улсын бүртгэлээс хасч, нийтэд мэдээлнэ.

/Энэ хэсгийг 2005 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

1. Цэцийн шийдвэрийн товч агуулгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд нэн даруй мэдээлнэ. Цэцийн хаалттай хуралдааны шийдвэрээс шаардлагатай хэсэг, заалтын агуулгыг нийтэд мэдээлнэ.
2. Цэцийн нээлттэй хуралдааны шийдвэрийг бүрэн эхээр нь “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтэлнэ.

48. ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ

2002 "н 06 S—<^p—^ph' 13- н S p
o (^ (^) & (^) (^) p > ”~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хангагч, хэрэглэгчийн харилцаа

8 дугаар зүйл. Гэрээ

- 8.4. Цэвэр усны үнэд орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө, төлөвлөгөөт засвар хийх үед цэвэр усаар хангах үйл ажиллагааг түр зогсоох тухай урьдчилан хэрэглэгчид мэдэгдэх буюу мэдээлэх хэрэгслээр зарлана.

49. ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ

1999 "н 05 S—<^p—^ph' 14- 'ЦБ S p
o (^ (^) & (^) (^) p > ”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХАМТЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР

- 17.4. Талууд хамтран ба дангаар хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлт, түүний явцыг хагас жил тутам буюу хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хугацаанд дүгнэж, нийт ажилтанд мэдээлнэ.

50. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

2003 "н 05 S—<^p—^ph' 23- н S p
o (^ (^) & (^) (^) p > ”~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Улсын бүртгэлийн жагсаалт

17 дугаар зүйл. Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх

- 17.3. Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан энэ тухай нийтэд мэдээлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх

22 дугаар зүйл. Үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах баримт бичиг

- 22.3. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлтийн талаар бүртгэх байгууллага тухай бүр нийтэд мэдээлнэ.

26 дугаар зүйл. Хуулийн этгээд татан буугдсаныг бүртгэх

- 26.4. Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухайгаа Иргэний хуулийн 32.1.1-д заасны дагуу тухай бүр нийтэд мэдээлнэ.

51. ХУУЛЬЧДААС СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ

2003 "н 05 S—<^p—^ph' 22-н S p

o'^(^)'↑^p>'~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хуульчдаас сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах

- 6.1.10. сонгон шалгаруулалтын дүнг мэдээлэх;

52. ХҮНСНИЙ ТУХАЙ

/yU'эЦЦ'—э' 'Бp—'<^/

1999 "н 10 S—<^p—^ph' 07-н S p

o'^(^)'↑^p>'~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, түүний тогтолцоо

13 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих улсын байцаагчийн бүрэн эрх

- 13.2. Улсын байцаагч дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 13.2.2. хүнсний гаралтай хордлого, хордлогот халдварын шалтгааныг тогтоох, таслан зогсоох, нийтэд шуурхай мэдээлэх;

53. ШУУДАНГИЙН ТУХАЙ

2003 "н 05 S—<^p—^ph' 15-н S p

o'^(^)'↑^p>'~

ТАВДУГААР БҮЛЭГ

Шуудангийн үйлчилгээний тариф

18 дугаар зүйл. Тарифын хэмжээ

- 18.4. Энэ хуулийн 18.3-т заасан шийдвэр гарснаас хойш энэ тухай 15 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

54. ШҮҮХИЙН ТУХАЙ

2002 "н 07 S—<^p—^ph' 04-ЦБ S p

o'^(^)'↑^p>'~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Шүүгчийг сонгон шалгаруулах, томилох

27 дугаар зүйл. Сонгон шалгаруулалт зарлах

- 27.1. Ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалт явуулах тухай зарлалыг сонгон шалгаруулалт явуулах тухай өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.



55. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ

2002 "н 01 SA<эep – ^ph' 10- н S p
o'^^:~^~^p>”~

II ХЭСЭГ

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАЛААРХИ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төлбөр төлөгчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах үйл ажиллагаа

42 дугаар зүйл. Өртэй этгээдийн бүртгэл

42.3. Өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дараа тухайн этгээдийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа

47 дугаар зүйл. Албадан дуудлага худалдааг нийтэд мэдээлэх, албадан дуудлага худалдааны оролцогч, албадан дуудлага худалдааны дэнчин

47.1. Албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч уг худалдаа эхлэхээс 14 хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр энэ тухай нийтэд мэдээлнэ.

56. ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

2003 "н 06 S—<^p – ^ph' 19- ЦБ S p
o'^^:~^~^p>”~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

6 дугаар зүйл. Эрхийн улсын бүртгэлийн талаархи мэдээлэл нээлттэй байх

- 6.1. Эрхийн улсын бүртгэлийн талаархи мэдээлэл нээлттэй байна.
- 6.2. Эрхийн улсын бүртгэлийн алба нь иргэн, хуулийн этгээдэд эрхийн улсын бүртгэлийн талаархи мэдээллийг мэдээлэл авах тухай бичгээр гаргасан хүсэлт, иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн төлөөлөгчид бичгээр олгосон итгэмжлэлийг үндэслэн зохих төлбөртэйгээр гаргаж өгөх бөгөөд мэдээлэл авсан этгээдийн хүсэлтээр мэдээлэлд дурдсан зүйлд холбогдох хэсгийг зохих төлбөртэйгээр хуулбарлан өгч болно.
- 6.4. Энэ хуулийн 6.2-т заасны дагуу гаргаж өгөх мэдээлэл нь өмчлөгчийн овог, эцэг/эх/-ийн нэр, нэр, оршин суугаа газар, өмчлөгч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газар, тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ, байршлын талаархи мэдээллийг агуулсан байна.
- 6.5. Эрхийн улсын бүртгэлийн алба нь энэ хуулийн 6.2-т заасан этгээдэд мөн хуулийн 6.4-т зааснаас өөр мэдээлэл өгөхгүй бөгөөд харин өмчлөгч нь бичгээр зөвшөөрсөн бол дэлгэрэнгүй мэдээллийг өгч болно.
- 6.6. Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуулийн 6.2, 6.3-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор мэдээлэл өгнө.

57. ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ

2002 "н 01 SA-ээр – рн' 10- н S p
о'""#""^p>"~

НАЙМДУГААР ХЭСЭГ

ШҮҮХИЙН АЖИЛЛАГАА

ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шүүх хуралдааны ерөнхий нөхцөл

235 дугаар зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

- 235.1. Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалахаас бусад тохиолдолд бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.
- 235.2. Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.

АРВАН НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

БУСАД ЗҮЙЛ

ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах

394 дүгээр зүйл. Хууль зөрчсөн ажиллагааны тухай лавлагаа өгөх

- 394.1. Цагаатгах тогтоол гарсан, гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болон гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүйгээс эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бол шүүх, прокурор нь иргэнд зөрчигдсөн эрхээ сэргээх болон бусад хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тайлбарлаж өгөх, түүнчлэн иргэний хүсэлтийн дагуу 1 сарын дотор өөрийн гаргасан шийдвэрийн талаар түүний ажиллаж байгаа байгууллагад бичгээр лавлагаа өгөх үүрэгтэй.
- 394.2. Иргэнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа уг ажиллагаа хууль бус болох нь нотлогдвол холбогдох хуулийн байгууллага тухайн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан цагаатгасан тухай шийдвэрийн талаар 10 хоногийн дотор холбогдох мэдээлэл хийж залруулах үүрэгтэй.

58. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ

2001 "н 02 S-[^]p – рн' 01- ЦТБ S p
о'""#""^p>"~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

8 дугаар зүйл. Зохицуулах газар

- 8.8. Зохицуулах газар санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж нийтэлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

21 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах

- 21.6. Зөвшөөрөл олгосон шийдвэр буюу олгохоос татгалзсан тухай үндэслэлийг нийтэлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ



ҮНЭ, ТАРИФ

27 дугаар зүйл. Тариф, гэрээний үнэ

- 27.5. Зохицуулах газар нь эрчим хүчний тарифт орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгчид мэдэгдэх буюу хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

2. Тодорхой мэдээллийг олон нийтэд заавал хүргэх үүрэг хүлээлгээгүй боловч нээлттэй байлгах үүрэг хүлээлгэсэн ХЭМ ХЭМЖЭЭ

59. АВТО ЗАМЫН ТУХАЙ

1998 "н 1 SA«ээр – ^pħ' 2- ħ S p
o (^ (^ ģ ģ ģ ģ p > " ~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Авто замын талаархи төрийн байгууллагуудын бүрэн эрх

- 15.1.5. авто зам, замын байгууламжийн ашиглалтын талаархи мэдээллийг мэдээллийн санд тухай бүр хүргүүлж байх;
- 16.2. Авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн санг аймаг, нийслэл дэх авто замын засвар, арчлалтыг хариуцсан байгууллага эрхлэн хөтөлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд жил тутам тогтоосон хугацаанд өгнө.

60. АМЬТНЫ АЙМГИЙН ТУХАЙ

2000 "н 05 S—< ^p — ^pħ' 05- ħ S p
o (^ (^ ģ ģ ģ ģ p > " ~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АМЬТНЫ АЙМГИЙГ ХАМГААЛАХ

6 дугаар зүйл. Амьтны аймгийг хамгаалах хэлбэр

- 6.1. Амьтны аймгийг дор дурдсан хэлбэрээр хамгаална. Үүнд:
- 6.1.11. иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах.

61. АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ

1995 "н 10 S—< ^p — ^pħ' 19- 'ЦБ S p
o (^ (^ ģ ģ ģ ģ p > " ~

9 дүгээр зүйл. Санал асуулга бэлтгэн явуулах ажлын ил тод байдал

1. Санал асуулга бэлтгэн явуулах ажил ил тод байна.
2. Төрийн байгууллагын харьяалал бүхий хэвлэл, мэдээллийн байгууллага санал асуулга бэлтгэн явуулах ажлын явц, санал асуулгын дүнг олон нийтэд шуурхай, үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.

62. АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

/ҮЦ'эЦЦ'—э' "Бр—'—' /
2000 "н 01 SA_{кээр}—'рн' 28-н S p
o'""#""p>"~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Архидан согтуурахтай хийх тэмцэл

9 дүгээр зүйл. Архидан согтуурахын эсрэг сурталчилгаа

9.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.

10 дугаар зүйл. Стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааг нийтэд мэдээлэх

10.2. Стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны хор хөнөөлийн талаархи мэдээллийг бүх төрлийн хэвлэл мэдээллийн байгууллага саадгүй хүлээн авч, нийтэд түгээх үүрэгтэй.

63. АУДИТЫН ТУХАЙ

1997 "н 5 S—'—'р—'рн' 1-ЦБ S p
o'""#""p>"~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Мэргэшсэн нягтлан бодогч, аудитор

22 дугаар зүйл. Сахилгын шийтгэл

3. Энэ зүйлийн нэг дэх хэсгийн 2, 3-т заасан шийтгэл ногдуулсан тохиолдолд энэ тухай нийтэд мэдээлнэ.

64. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ

(ҮЦ'эЦЦ'—э' "Бр—'—' /
2006 "н 07—'рн' 08 S p
с рЦБ' "pS". o'""#""p>"~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Ашигт малтмалын салбар дахь төрийн зохицуулалт

11 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

- 11.1.4. нууцын зэрэглэлд хамруулснаас бусад геологи, уул уурхайн мэдээлэл, энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өгсөн мэдээллийг сонирхсон этгээдэд хүргэх;
- 11.1.5. үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах;
- 11.1.22. сонирхсон этгээдэд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй танилцах бололцоо олгох, эдгээр бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар зохих байгууллагад мэдэгдэж нийтэд мэдээлэх.
- 14.8. Энэ хуулийн 14.2-т зааснаар тогтоосон газрыг тусгай хэрэгцээнд байлгах хугацаа дууссан бол төрийн захиргааны байгууллага энэ тухай нийтэд мэдээлэх бөгөөд урьд нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд ийнхүү мэдээлснээс хойш 1



сарын дотор хүсэлт гаргавал тэрээр тусгай зөвшөөрлийг тэргүүн ээлжинд авах давуу эрх эдэлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Ашигт малтмал эрэх, хайх

16 дугаар зүйл. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгаа болон эрдэм шинжилгээний ажил

16.4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны мэдээлэл төрийн мэдээллийн сангийн үндсэн бүрэлдэхүүн бөгөөд нийтэд нээлттэй байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Мэдээлэл, төлбөрийн хуваарилалт, нөхөн төлбөр, санхүү бүртгэлийн онцлог

57 дугаар зүйл. Ашигт малтмалтай холбоотой мэдээлэл, бүртгэлтэй танилцах

57.4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаархи мэдээллийг байгаль орчны болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээнэ.

65. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ

2000 "н 05 S—<^p — ^ph' 05- н S p
o ('^'±^^^p > "'

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Аялал жуулчлалын байгууллага

8 дугаар зүйл. Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх

8.1. Аялал жуулчлалын байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.4. Монгол Улсын нийгэм, эдийн засаг, төрийн байгуулалт, түүх соёл, ёс заншил, зан үйлийн талаар жуулчдад үнэн бодит мэдээлэл өгөх;

66. БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

2002 "н 05 S—<^p — ^ph' 03- н S p
o ('^'±^^^p > "'

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш

22 дугаар зүйл. Багшийн эрх, үүрэг

22.1. Багш нь Боловсролын тухай хуулийн 44.2-т зааснаас гадна дараахь үүрэгтэй:

22.1.8. бага насны хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар сургуулийн эмч болон эцэг, эх, асран хамгаалагчид шаардлагатай мэдээлэл өгөх.

67. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ

1995 "н 3 S—<^p — ^ph' 30- н S p
o ('^'±^^^p > "'

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН САН, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

10 дугаар зүйл. Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээ

3. Хяналт-шинжилгээний сүлжээгээр дараахь ажлыг хэрэгжүүлнэ:
 - 2/ байгаль орчин, түүний баялгийн талаар хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах;

68. БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ

1995 "н 5 S—<^p—^ph' 16- н S p
o'^^'ф^^^p>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

7 дугаар зүйл. Байгууллагын нууцтай танилцах

3. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж нууцалсан байгууллагын нууцыг ил болгох эрхтэй бөгөөд тухайн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбогдолтой байгууллагын нууцад хамаарах зарим тодорхой мэдээллийг бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахгүй тохиолдолд нийтэд мэдээлж болно.

**69. БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН
ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, ЗЭЭЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ**

1995 "н 10 S—<^p—^ph' 31- ЦБ S p
o'^^'ф^^^p>"~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Мөнгөн хадгаламж

3 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн тухай ойлголт

2. Хадгалагч нь хадгалуулагчтай мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулах үедээ өөрийн үйл ажиллагаатай холбогдсон үнэн зөв мэдээлэл өгнө.
3. Хадгалагч мөнгөн хадгаламжийн хүү, хугацааг нийтэд зарлах бөгөөд уг нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн хадгалуулагч мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулж, мөнгөн хөрөнгөө хадгалуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн үйл ажиллагаа

21 дүгээр зүйл. Зээл олгох ажиллагаа

1. Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тогтоон нийтэд мэдээлнэ.



70. БАНКНЫ ТУХАЙ

1996 "н 9 SA-ээр – пн' 3- н S p
o' (^^) & ^^^ ^ p > " ~

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Банкинд онцгой дэглэм тогтоох

34 дүгээр зүйл. Онцгой дэглэм тогтоох шийдвэр

2. Монголбанк онцгой дэглэм тогтоосон тухай шийдвэрээ нийтэд мэдээлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Банкны эрх хүлээн авах

43 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авагчийн бүрэн эрх

Банкны эрх хүлээн авагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 6/ шаардлагатай гэж үзсэн мэдээллийг нийтэд мэдээлэх;

44 дүгээр зүйл. Банкны эрх хүлээн авагчийн нэн даруй авах арга хэмжээ

2. Банкныг албадан татан буулгах тухай шийдвэр гарсан тохиолдолд банкны эрх хүлээн авагч нь дараахь арга хэмжээ авна:
 - 1/ худалдаж борлуулах актив хөрөнгийн жагсаалт, түүнийг борлуулах үнэлгээг тогтоож, холбогдох этгээдэд мэдээлэх;
 - 2/ банкнаас авлагатай этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах хугацааг тогтоож, нийтэд мэдээлэх;

71. БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН ТУХАЙ

2003 "н 05 S- < ^ ^ p – ^ p h ' 02- н S p
o' (^^) & ^^^ ^ p > " ~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

4 дүгээр зүйл. Барааны тэмдэг, газар зүйн заалтын талаархи оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

- 4.1. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "байгууллага" гэх/ нь барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэхтэй холбогдсон дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 4.1.3. барааны тэмдэг, газар зүйн заалтын талаархи маргааныг шүүхээр хянан шийдвэрлэхэд лавлагаа өгөх;
 - 4.1.6. барааны тэмдэг, түүнтэй холбоотой гэрээ, газар зүйн заалтын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, тэдгээртэй холбоотой мэдээллийг хэвлэн нийтлэх;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Барааны тэмдэг, түүнийг бүртгэх, гэрчилгээ олгох

10 дугаар зүйл. Барааны тэмдгийн бүртгэл хүчинтэй байх хугацаа, түүнийг сунгах

- 10.6. Барааны тэмдгийн бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгасан, эсхүл барааны тэмдгийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан бол оюуны өмчийн байгууллага энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтэлнэ.

14 дүгээр зүйл. Хамтын тэмдэг, гэрчлэх тэмдгийн мэдүүлэгт шүүлт хийх, гэрчилгээ олгох

- 14.2. Оюуны өмчийн байгууллага нь хамтын тэмдэг, гэрчлэх тэмдгийн ном зүйг тэдгээрийг ашиглах журмын хамт хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтэлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Газар зүйн заалт, түүнийг бүртгэх, гэрчилгээ олгох

18 дугаар зүйл. Газар зүйн заалтыг бүртгэх, гэрчилгээ олгох

- 18.5. Оюуны өмчийн байгууллага нь газар зүйн заалтын нэр, ном зүйг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтэлнэ.

72. ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

1994 "н 5 S—<^p—^ph' 12- н S p
o'^(^)^&^(^)^p>"~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

5 дугаар зүйл. Монгол Улсын валютын зах, ханш

2. Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг валютын зах дээр арилжааны банкуудын худалдсан, худалдаж авсан гадаад валютын ханшид үндэслэн тус улсын гадаад худалдаанд зонхилон хэрэглэж байгаа тогтвортой ханш бүхий чөлөөтэй хөрвөдөг аль нэг гадаад валютын тухайн үеийн ханштай жишин тогтоож нийтэд зарлана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Валютын гүйлгээ хийх

11 дүгээр зүйл. Арилжааны банкны эрхлэх валютын гүйлгээ,эрх, үүрэг

2. Валютын гүйлгээ эрхэлж байгаа арилжааны банк дараахь үүрэгтэй байна:

1/ валютын гүйлгээний талаарх тайлан, мэдээг тогтоосон журмын дагуу гаргах, мэдээлж байх;

73. ГАЗРЫН ТУХАЙ

/УЦ'эЦЦ'—э' 'Бp—' <^/
2002 "н 06 S—<^p—^ph' 07- н S p
o'^(^)^&^(^)^p>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Газрын харилцааны талаархи төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

- 23.3. Аймаг, нийслэлийн газрын алба дараахь эрх хэмжээтэй байна:
23.3.3. газрын кадастр эрхлэх, аймаг, нийслэлийн газрын мэдээллийн сан байгуулж, олон нийтэд мэдээллээр үйлчлэх;

74. ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ

2003 "н 06 S—<^p—^ph' 20- ЦБ S p
o'^(^)^&^(^)^p>"~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл



6 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах

6.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагаа, гамшиг, түүний аюул, хор уршиг, үр дагаврын тухай мэдээлэл нь хуульд өөрөөр заагаагүй бол нийтэд нээлттэй, ил тод байна.

/Энэ хэсэгт 2005 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

24.1.14. гамшгаас хамгаалах тухай мэдээлэл, сурталчилгааг хэвлэл, мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд хүргэх;

/Энэ заалтыг 2005 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/

75. ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ

1997 "н 10 S—<^p — ^ph' 31- ЦБ S p

o (^ ^ : ^ ^ ^ p) ^

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Геодези, зураг зүйн үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүрэг

5 дугаар зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг

5.5.9. төрөл бүрийн масштабтай байр зүйн болон дэвсгэр зургийг олгох, худалдах, шилжүүлэх, мэдээллээр хангах.

76. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

2004 "н 05 S—<^p — ^ph' 13- н S p

o (^ ^ : ^ ^ ^ p) ^

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл өгөх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ

13 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл

13.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмнэлгийн мэргэжилтэн албан үүргээ биелүүлж байх үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдолд цагдаагийн байгууллага, боломжгүй бол нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

77. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ

2004 "н 04 SA<эep — ^ph' 30- н S p

o (^ ^ : ^ ^ ^ p) ^

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

11.7. Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэл, аудит



20 дугаар зүйл. Аудит

20.3. Зохицуулах хороо энэ хуулийн 20.2-т заасан аудиторын нэрсийн жагсаалт болон түүний өөрчлөлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Албадлага

38 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

38.8. Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

39 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

39.5. Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

78. ДААТГАЛЫН ТУХАЙ

(ҮЦ'эЦЦ'—э' 'Бр— (э')

2004 "н 04 SA^{кээр} — ^ph'30- н S p

o ^^^#^^^p> ^~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагааг төрөөс зохицуулах

13 дугаар зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

13.1. Зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.4. даатгалын дотоод, гадаад зах зээлийг судлах, даатгалын талаархи албан ёсны мэдээлэл гаргах;

14 дүгээр зүйл. Даатгалын багц дүрэм

14.2. Даатгалын багц дүрэмд дараахь дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлага, хэмжээ багтана:

14.2.21. энэ хуульд заасан мэдээллийг хэвлэн нийтлэх журам.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

20 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

20.9. Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэл, аудит

29 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

29.5. Даатгагч энэ хуулийн 29.4-т заасан шаардлагыг хангасан санхүүгийн тайланг улирал тутам, аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлнэ.

33 дугаар зүйл. Аудит

33.3. Зохицуулах хороо энэ хуулийн 33.2-т заасан эрх бүхий аудиторын нэрсийн жагсаалт болон түүнд өөрчлөлт орсон тухай бүр даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.



НАЙМДУГААР БҮЛЭГ

Актуарч, актуарын хяналт шалгалт, тайлан

39 дүгээр зүйл. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох

39.3. Зохицуулах хороо энэ хуулийн 39.1-д заасны дагуу эрх авсан актуарчийн нэрсийн жагсаалт, түүний өөрчлөлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Зах зээлийн ёс зүй

58 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа

58.2. Даатгагчийн болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Зохицуулах хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Албадлага

71 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос үүсэх үр дагавар

71.3. Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон талаархи мэдээллийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

79. ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ

2000 "н 10 S—<^p —^ph' 05- н S p
o (^ (^) ; ^ ^ ^ ^ p > " ~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Дипломат алба, түүний тогтолцоо, чиг үүрэг

5 дугаар зүйл. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

5.1. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас гадна өөрийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ:

5.1.13. Монгол Улсыг хилийн чанадад сурталчлах, албан ёсны мэдээлэл түгээх, монголын олон нийтийг дипломат үйл ажиллагаа, олон улсын байдлын талаархи цаг үеийн мэдээллээр хангах;

80. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

1999 "н 10 S—<^p —^ph' 14- 'ЦБ S p
o (^ (^) ; ^ ^ ^ ^ p > " ~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

7 дугаар зүйл. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн чиг үүрэг

7.1. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.7. иргэний бүртгэлтэй холбогдсон мэдээлэл, лавлагаагаар иргэд, байгууллагад хүсэлтийнх нь дагуу үйлчлэх;

81. ИРГЭНИЙ ХУУЛЬ

2002 "н 01 SA<ээр – ^рн' 10- н S p
o' ^^^^p>"

I ХЭСЭГ

ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

II ДЭД ХЭСЭГ

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИД

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хуулийн этгээд

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

32 дугаар зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах

32.3. Татан буулгах комисс нь хуулийн этгээд татан буугдсан тухай нийтэд мэдээлнэ.

32.11. Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухай нийтэд мэдээлнэ.

III ХЭСЭГ

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ

I ДЭД ХЭСЭГ

БУСДЫН ӨМЧЛӨЛД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН

ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Худалдах-худалдан авах болон арилжаа

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

243 дугаар зүйл. Худалдах-худалдан авах гэрээ

243.2. Худалдагч нь худалдаж байгаа эд хөрөнгийн зориулалт, хэрэглээний шинж чанар, хадгалах, хэрэглэх, тээвэрлэх нөхцөл, журам, баталгаат болон эдэлгээний хугацаа, үйлдвэрлэгчтэй холбогдсон үнэн зөв, бүрэн мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

246 дугаар зүйл. Эд хөрөнгө илгээх талаар худалдагчийн хүлээх үүрэг

246.3. Тээвэрлэлтийн явцад эд хөрөнгийг даатгуулах үүрэг худалдагч хүлээгээгүй бол худалдан авагчийн хүсэлтээр даатгалын гэрээ байгуулахад шаардагдах, өөрт байгаа бүхий л мэдээллийг түүнд өгөх үүрэг хүлээнэ.

II ДЭД ХЭСЭГ

БУСДЫН ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ

ХОЛБОГДСОН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Санхүүгийн түрээс /лизинг/

316 дугаар зүйл. Санхүүгийн түрээсийн гэрээнд гуравдагч этгээдийн эрх, үүрэг



- 316.2. Гэрээнд заасан бол гуравдагч этгээд нь гэрээний зүйлд засвар үйлчилгээ хийх, түүнийг тохируулах, суурилуулах, ашиглахтай холбоотой үнэн зөв мэдээллийг түрээслэгчид өгөх үүрэгтэй.

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Франчайз

334 дүгээр зүйл. Гэрээний талуудын үүрэг

- 334.1. Эрх шилжүүлэгч дараахь үүрэгтэй:

334.1.3. эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

338 дугаар зүйл. Талуудын хүлээх хариуцлага

- 338.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэл болон өгсөн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

388 дугаар зүйл. Тээвэрлэгчид ачааг хүлээлгэн өгөх

- 388.7. Ачаа илгээгч нь ачааг зохих газарт хүргэхэд шаардагдах гаалийн болон бусад бүх баримт бичгийг дагалдах бичигт хавсаргах буюу тээвэрлэгчид өгч, тээвэрлэгчийг зохих мэдээллээр бүрэн хангах үүрэгтэй.
- 388.9. Тээвэрлэгчийн буруутай үйл ажиллагаанаас бусад тохиолдолд ачаа илгээгч нь баримт бичиг, мэдээллийн дутуу болон буруугаас учирсан гэм хорыг тээвэрлэгчийн өмнө хариуцна.

ГУЧИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ДААЛГАВАР

400 дугаар зүйл. Даалгавар гүйцэтгэгчийн үүрэг

- 400.3. Даалгавар гүйцэтгэгч нь даалгавар өгөгчийн шаардлагаар гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар мэдээлэх, даалгавар гүйцэтгэхтэй холбогдуулан хүлээж авсан бүх зүйлийг даалгавар өгөгчид нэн даруй шилжүүлэх үүрэгтэй.

404 дүгээр зүйл. Даалгаврыг өөр этгээдэд шилжүүлэх

- 404.2. Даалгаврыг бүрэн буюу түүний зарим хэсгийг орлон гүйцэтгэгчид шилжүүлсэн даалгавар гүйцэтгэгч энэ тухай даалгавар өгөгчид даруй мэдэгдэх бөгөөд орлон гүйцэтгэгчийн талаархи мэдээллээр даалгавар өгөгчийг хангах үүрэгтэй.

ГУЧИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Илгээмжийн гэрээ

408 дугаар зүйл. Илгээгчийн эрх, үүрэг

- 408.3. Захиалагч татгалзаж байгаага бичгээр тусгайлан илэрхийлээгүй бол илгээгч нь захиалагчийн зардлаар илгээгчийн үйлдлийн улмаас учирч болзошгүй гэм хорын даатгалын гэрээг өөрийн сонгосон даатгагчтай байгуулах бөгөөд энэ тухай захиалагчид мэдээлэх үүрэгтэй.
- 408.4. Энэ хуулийн 408.3-т заасан даатгалын гэрээг баримтлан захиалагч нь учирсан гэм хорын талаар илгээгчид нэн даруй мэдээлэх бөгөөд илгээгч уг мэдээллийг даатгагчид дамжуулна.

409 дүгээр зүйл. Захиалагчийн эрх, үүрэг

- 409.1. Захиалагч илгээмжийн талаархи болон бусад шаардлагатай мэдээлэл, түүний тээвэрлэлттэй холбоотой баримт бичгийг бүрдүүлж илгээгчид өгөх үүрэгтэй.
- 409.2. Захиалагч энэ хуулийн 409.1-д заасан мэдээллийн үнэн зөвийг нотлох баримтыг илгээгчид шилжүүлж өгөх үүрэгтэй.
- 409.3. Захиалагч тээвэрлүүлэхээр шилжүүлсэн илгээмжийн онцлог шинж чанар, учруулж болзошгүй аюул, аюулгүй ажиллагааны талаар илгээгчид мэдээлнэ.

ГУЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Зуучлал

Хоёрдугаар дэд бүлэг

Худалдааны зуучлагч, комисс

414 дүгээр зүйл. Худалдааны зуучлагчийн хөтлөх тэмдэглэл

414.2. Худалдааны зуучлагч гэрээний талуудын шаардсан үед тэмдэглэлээс зуучлалын тусламжтайгаар байгуулсан хэлцлийн тухай мэдээллийг агуулсан өөрийн гарын үсэгтэй баримтыг олгох үүрэгтэй.

ДӨЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах

429 дүгээр зүйл. Агуулахын баримт

429.7. Агуулахын баримтыг бичилтийн дагуу шилжүүлсэн бол хадгалагч нь түүнд дурдсан мэдээллийн үнэн зөвийг баримт эзэмшигчийн өмнө хариуцах бөгөөд харин уг мэдээллийг хадгалуулагч, эсхүл гуравдагч этгээдийн өгсөн мэдээллийг үндэслэсэн гэж уг баримтад тэмдэглэсэн бол хадгалагч хариуцлага хүлээхгүй.

ДӨЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Даатгал

436 дугаар зүйл. Гэрээ цуцалж болох ноцтой нөхцөл байдал

436.1. Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш бий болсон ийм нөхцөл байдлын талаар даатгагчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

Хоёрдугаар дэд бүлэг

Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох

452 дугаар зүйл. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлийн хүү

452.3. Зээлдүүлэгч зээлийн хүүгийнхээ хэмжээг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Гуравдугаар дэд бүлэг

Мөнгөн хадгаламж

456 дугаар зүйл. Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн мэдээлэл

456.1. Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд санхүүгийн тайлан, мэдээллийг хуульд заасан хугацаанд нийтэд мэдээлэх үүрэгтэй.

456.2. Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд өөрийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдлын талаархи мэдээллийг хадгалуулагчид гаргаж өгөх үүрэгтэй.

ДӨЧИН ТАВДУГААР БҮЛЭГ

Батлан даалт

462 дугаар зүйл. Үндсэн гэрээний тухай мэдээлэх үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг

462.2. Батлан даагч шаардсан бол үүрэг гүйцэтгүүлэгч үндсэн гэрээгээр үүрэг гүйцэтгэгчийн хүлээх үүргийн талаар түүнд үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй.

IY ХЭСЭГ

ГЭРЭЭНИЙ БУС ҮҮРЭГ

I ДЭД ХЭСЭГ



ХУУЛЬД ЗААСНААР ҮҮСЭХ ҮҮРЭГ
ТАВИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Хуулийн дагуу үүсэх үүргийн харилцаа
Гуравдугаар дэд бүлэг
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих

495 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулснаас үүсэх үүрэг

495.7. Бусдын эрхийг зөрчсөн этгээд тухайн эд хөрөнгийг ашигласнаас олсон ашгийн талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.

82. ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Эрүүл мэндийн даатгал

12 дугаар зүйл. Даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр

12.9. Энэ хуулийн 7.6-д заасан хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалт, уг эмийн үнийн даатгалын сангаас олгох хувь, хэмжээг даатгалын зөвлөл баталж, нийтэд мэдээлнэ.

/Энэ хэсэгт 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

83. КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ

1999 "н 12 – ^ph' 16- н S p
o'^^f^^^p>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Кадастрын зураглалын харилцаа

7.4. Үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь дараахь үүрэгтэй байна:

7.4.1. кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах;

7.5. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь кадастрын зураглалын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.5.3. захиалагч, гүйцэтгэгчийг холбогдох мэдээллээр хангах;

84. КОМПАНИЙН ТУХАЙ

1999 "н 07 S—<^p — ^ph' 02- н S p
o'^^f^^^p>”~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, өрийг хувьцаагаар солих

27 дугаар зүйл. Компанийг татан буулгахад өр төлбөрийг барагдуулах журам

27.2. Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг нийтэд мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах тухайг нийтэд мэдээлснээс хойш 2 сараас багагүй, 6 сараас ихгүй байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ



Компани өөрийн үнэт цаасыг худалдан авах болон эргүүлэн авах

55.7. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь эргүүлэн авах хувьцааны зах зээлийн үнийн талаархи нэмэлт мэдээллээр хувь нийлүүлэгчдийг хангана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Компанийн удирдлага

66 дугаар зүйл. Хурлын зар мэдээг хүргэх

66.1. Хурал зарлагч этгээд нь хурлын тухай зар мэдээг хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдэд мэдээлэх үүрэг хүлээнэ.

66.3. Хурлын тухай зар мэдээнд компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар, бүртгэлийн өдөр, хурлаар хэлэлцэх асуудал болон гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох бичиг баримттай танилцах журам эзрэг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад мэдээллийг тусгасан байна.

Санал авах хуудсаар саналыг урьдчилан авах тохиолдолд санал авах хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацааг тусгайлан мэдээлнэ.

66.5. Компани нь хурал хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хувь нийлүүлэгчид дээрх бичиг баримттай танилцах боломжийг хангах үүрэг хүлээнэ.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

93 дугаар зүйл. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан

93.1. Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Хувьцаат компанийн хувьд Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

85. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

2004 "н 05 S—[^]p —[^]pн' 14- 'ЦБ S p
o'^'^'±'^'^^p>'~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр

11 дүгээр зүйл. Алдуул малыг бүртгэх, мэдээлэх

11.1. Нутгийн захиргааны байгууллага алдуул малыг бүртгэж, алдуул малын талаар цагдаагийн байгууллага болон олон нийтэд тогтмол мэдээлж байна.

86. МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

/УЦ'эЦЦ'—э' ''Бp— —'з~/
2001 "н 06 —[^]pн' 07- 'н S p
o'^'^'±'^'^^p>'~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

4 дүгээр зүйл. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх



89. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ

1993 "н 5 S—[^]р—[^]рн'6-н S p
o'^(^)^⁺^(^)^⁺р>"~

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Засгийн газрын ажлын зохион байгуулалт

29 дүгээр зүйл. Засгийн газрын хуралдаан

4. Хуралдааныг Ерөнхий сайдын шийдвэрлэснээр нээлттэй буюу хаалттай явуулж болох бөгөөд хуулиар хамгаалсан нууцад хамаарахаас бусад шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.

90. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

/ҮЦ'эЦЦ'—э' "Бр—[^]р/

2005 "н 12—[^]рн'29-ЦБ S p,
o'^(^)^⁺^(^)^⁺р>"~

31 дүгээр зүйл.Нэр дэвшигч татгалзах, нэр дэвшигчийг татан гаргах

- 31.3. Тойргийн хороо энэ хуулийн 31.2-т заасан шийдвэрийг хүлээн авмагц тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрээ хүчингүйд тооцсон тухай шийдвэр гаргаж, энэ тухай Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдэх бөгөөд тэрээр нийтэд мэдээлнэ.

33 дугаар зүйл.Нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах

- 33.1. Нэр дэвшигч энэ хуулийн 30.12, 30.13-т заасны дагуу бүртгүүлж, 30.16-д заасны дагуу нийтэд зарлагдсаны дараа түүнийг нэр дэвшигчийн жагсаалтаас хасах талаархи энэ хуульд заасан үндэслэл тогтоогдвол Сонгуулийн ерөнхий хороо энэ тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдээлнэ.

46 дугаар зүйл.Сонгуулийг ажиглагч

- 46.4.11. ажиглалтын тайлангаа нийтэд тавих, хэвлэн нийтлэх.

91. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ

/ҮЦ'эЦЦ'—э' "Бр—[^]р/

2006 "н 01—[^]рн'26 S p
с рЦБ' "pS". o'^(^)^⁺^(^)^⁺р>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтэц

29 дүгээр зүйл. Чуулганы хуралдааны нийтлэг журам

- 29.12. Иргэд, гадаад, дотоодын зочид төлөөлөгчид чуулганы ажиллагаатай танилцах, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжлага хийх эрхтэй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг Улсын Их Хурлын дарга батална.

92. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ

2000 "н 12 S—[^]р—[^]рн'07-н S p
o'^(^)^⁺^(^)^⁺р>"~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ



Комисс, түүний гишүүний бүрэн эрх

13 дугаар зүйл. Комиссын бүрэн эрх

13.2. Комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараахь үйл ажиллагаа явуулна:

- 13.2.4. хүний эрхийн талаархи хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах

93. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ

2002 "н 5 S—<^p—^pн' 3-н S p
o'^(^)^p>"

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага

7 дугаар зүйл. Боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.2. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн боловсрол, сургалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 7.2.1. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, энэ тухай мэдээллээр байгууллага, иргэнийг хангах;

94. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

(ҮЦ'эЦЦ'—э' "Бр—' ^)

2001 "н 12 S—<^p—^pн' 13-н S p
o'^(^)^p>"

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Санхүүгийн тайлан гаргах ажлын зохион байгуулалт

12 дугаар зүйл. Санхүүгийн тайланг тушаах

12.3. Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа тушаагаагүй бол харилцагч санхүүгийн байгууллага энэ тухай нийтэд мэдээлнэ.

95. ПАТЕНТИЙН ТУХАЙ

/ҮЦ'эЦЦ'—э' "Бр—' ^/

2006 "н 01 —^pн' 19 S p
с pЦБ' "pS". o'^(^)^p>"

ТАВДУГААР БҮЛЭГ

Оюуны өмчийн байгууллага

26 дугаар зүйл. Оюуны өмчийн газар

26.1. Монгол Улсад шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын асуудлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Оюуны өмчийн газар хариуцан дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ:

- 26.1.5. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын тухай мэдээллийг хэвлэн нийтлэх;

96. САДАР САМУУН ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

1998 "н 1 SA_{хээр} – ^ph' 22-н S p
o'^(^)^#^(^)^p>"~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Садар самуун явдлыг хориглох

6 дугаар зүйл. Садар самуун явдалтай тэмцэх талаар аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

- 6.1. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон эрүүл мэнд, хэвлэл, мэдээлэл, гэгээрлийн байгууллагууд садар самуун явдлын хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах, бэлэгсийн халдварт болон дархлалын олдмол хомсдол өвчнөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа явуулах үүрэгтэй.

97. СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

2006 "н 01 – ^ph' 12 S p
c pЦБ' "pS". o'^(^)^#^(^)^p>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хороо, түүний гишүүний бүрэн эрх, баталгаа

7 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх

- 7.1. Хороо дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 7.1.6. ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах;

98. СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХОЁРДУГААР БҮЛЭГ

2003 "н 05 S—<^p – ^ph' 15-н S p
o'^(^)^#^(^)^p>"~

Стандартчилал ба техникийн зохицуулалт

11 дүгээр зүйл. Мэдээлэл

- 11.4. Мэдээлэл, лавлагааны төв нь үнэн зөв, бодит мэдээллээр нийтэд үйлчилнэ.

99. СТАТИСТИКИЙН ТУХАЙ

/УЦ'эЦЦ'–э' "Бp—'<^/
1997 "н 6 S—<^p – ^ph' 5-н S p
o'^(^)^#^(^)^p>"~

ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ БҮРЭН ЭРХ

18 дугаар зүйл. Яам, Монголбанк, төрийн бусад албан газар, бүх шатны Засаг даргын статистикийн мэдээллийн талаархи нийтлэг бүрэн эрх

/Энэ зүйлийн гарчигт 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/



Яам, төрийн бусад албан газар, бүх шатны Засаг дарга статистикийн мэдээллийн талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3/ мэдээлэл, судалгааны дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх;

100. ТАХИР ДУТУУ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ

/Э/э>—‘ЦБ’ эрЦБ< 1998 ”н 11 SA<ээр—^ph’ 12-”н SpЦБ’>—‘Ц^р pЦЦ’— /
1995 ”н 12 S—<^p—^ph’ 19-’ЦБ S p
o‘^^:~^^^p>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын арга хэмжээ

8 дугаар зүйл. Тахир дутуу хүний боловсрол, сургалт

9. Тухайн ажлын нөхцөл, машин, тоног төхөөрөмжийн ажиллагаа нь тахир дутуу хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учруулахааргүй байвал түүний техниктэй харьцаж сурах сургалтыг төрөөс дэмжиж, энэ талаархи мэдээллийг түүнд үнэ төлбөргүй хүргэнэ.

101. ТӨРИЙН АЛБАН ЁСНЫ ХЭЛНИЙ ТУХАЙ

2003 ”н 05 S—<^p—^ph’ 15-”н S p
o‘^^:~^^^p>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төрийн албан ёсны хэлийг хэрэглэх

6 дугаар зүйл. Төрийн хэлний зөвлөл, түүний чиг үүрэг

- 6.6. Зөвлөл нь төрийн албан ёсны хэлний талаар дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 6.6.2. мөрдөгдөж буй нэр томъёо, үг хэллэг нийгмийн болоод шинжлэх ухааны хэрэгцээ, шаардлагад хэрхэн нийцэж, хэрэглэгдэж байгаад судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл өөрчилж, энэ талаар олон нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх;

102. ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ

2002 ”н 06 S—<^p—^ph’ 28-”н S p
o‘^^:~^^^p>”~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

4 дүгээр зүйл. Төрийн албаны зарчим

- 4.1. Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн.
- 4.2. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд дараахь зарчмыг баримтална:
- 4.2.2. ил тод байх;
- 4.2.3. ард түмэнд үйлчлэх;

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, журам

17 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах

- 17.5. Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй.

103. ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ

2003 "н 01 SA^{кээр} – ^р^н '03-н S p
о^{''''#''''^p>}"

ТАВДУГААР БҮЛЭГ

Олон нийтийг мэдээллээр хангах

25 дугаар зүйл. Мэдээллээр хангах

- 25.1. Үндэсний аудитын газар хүсэлт ирүүлсэн хүмүүст төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг хэвлэмэл эхээр нь буюу хувилж өгнө.

104. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

1997 "н 2 S—<^p – ^р^н '6-н S p
о^{''''#''''^p>}"

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

9 дүгээр зүйл. Төрөөс төрийн бус байгууллагатай харилцах

4. Төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон төрийн нууцад үл хамаарах мэдээлэл төрийн бус байгууллагад нээлттэй байна.

105. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ

2002 "н 06 S—<^p – ^р^н '27-н S p
о^{''''#''''^p>}"

ТАВДУГААР БҮЛЭГ

48 дугаар зүйл. Албан хаагчийг томилох

- 48.2. Ерөнхий менежер нь өөрийн байгууллагын удирдах албан тушаалтныг ямар шалгуураар томилсон тухайгаа төрийн албаны төв байгууллагад бичгээр мэдэгдэнэ. Төрийн албаны төв байгууллага нь сонирхсон байгууллага, хувь хүмүүсийг уг мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.

106. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮСИЙН ТУХАЙ

1997 "н 10 S—<^p – ^р^н '23-н S p
о^{''''#''''^p>}"

6 дугаар зүйл. Орчны бүсийн зөвлөл

- 6.4. Зөвлөл дараахь эрх, үүрэгтэй:
6.4.5. тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн тухай хууль тогтоомжийг сурталчилах, зохих мэдээллийг олон нийтэд түгээх.



107. ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ТУХАЙ

1999 "н 06 S—<^p—^ph' 10- н S p
o'^(^):^(^)^p>"~

11 дүгээр зүйл. Тэтгэвэр олгох

- 11.2. Тэтгэвэр авагчид данснаас тооцож олгосон тэтгэвэр, дансны үлдэгдлийн талаар түүнд мэдээлж байна.

108. ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Намын санхүүжилт

18 дугаар зүйл. Гишүүний татвар, намд өгөх хандив

- 18.4. Нам хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна.

20 дугаар зүйл. Намын санхүүгийн хяналт

- 20.3. Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.

109. УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ

1998 "н 1 SA<ээр—^ph' 2- н S p
o'^(^):^(^)^p>"~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

21 дүгээр зүйл. Цагаатгагдсан хэлмэгдэгч нас барсан тухай мэдээлэх

- 21.1. Цагаатгагдсан хэлмэгдэгч хэлмэгдүүлэлтийн явцад нас барсан бол түүний хэргийг архивлан хадгалж байгаа байгууллага хэзээ, ямар шалтгаанаар нас барсан болон оршуулсан газрын тухай, хэрэв энэ талаар холбогдох баримт сэлт байхгүй бол энэ тухайгаа сонирхогч этгээдэд мэдээлнэ.

110. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ

1996 "н 3 S—<^p—^ph' 22- н S p
o'^(^):^(^)^p>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Ургамлын хорио цээр

9 дүгээр зүйл. Ургамлын хорио цээрийн дэглэм

4. Ургамал хамгааллын алба нь ургамлын хорио цээр тогтоосон, хориотой өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал тархсан болон тархаж болзошгүй нутаг дэвсгэрийн талаар нийтэд зарлан мэдээлнэ.

111. УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

1997 "н 11 SA<ээр – ^рh' 13- н S p
o'^(^)'&^^^>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

6 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

- 6.1.2. ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай үйлчлэх, байгалийн гамшиг, орчны бохирдлоос сэрэмжлүүлэх арга хэмжээ авах;

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ус цаг уур, орчны мэдээлэл

15 дугаар зүйл. Ус цаг уур, орчны мэдээллээр хэрэглэгчийг хангах

- 15.1. Урьдчилсан мэдээ, байгалийн гамшгийн тухай урьдчилан сэргийлэх мэдээг аймаг, бүс нутаг, улс орны хэмжээнд нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээнэ.

112. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

1997 "н 5 S—<^p – ^рh' 1-'ЦТ S p
o'^(^)'&^^^>”~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн журам 4 дүгээр зүйл. Цэцэд маргааныг ил тод хянан шийдвэрлэх

1. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг ил тод явуулна. Төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах онцгой шаардлагатайгаас бусад тохиолдолд Цэцийн хуралдааныг нээлттэй хийнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Цэцийн шийдвэр

34 дүгээр зүйл. Цэцийн шийдвэрийг мэдээлэх

1. Цэцийн шийдвэрийн товч агуулгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд нэн даруй мэдээлнэ. Цэцийн хаалттай хуралдааны шийдвэрээс шаардлагатай хэсэг, заалтын агуулгыг нийтэд мэдээлнэ.

113. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

2002 "н 12 S—<^p – ^рh' 12- н S p
o'^(^)'&^^^>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

8 дугаар зүйл. Үнэт цаас гаргах тухай танилцуулгыг нийтэд мэдээлэх

- 8.1. Хороо нь үнэт цаас гаргах тухай танилцуулгыг нийтэд мэдээлэх тухай журам тогтооно.
- 8.2. Үнэт цаас гаргагч болон тухайн үнэт цаасыг зуучлан арилжих мэргэжлийн байгууллага нь үнэт цаасыг арилжихаас өмнө сонирхогч этгээдийг шаардлагатай мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах

14 дүгээр зүйл. Хөрөнгө оруулагчид үнэт цаасны гүйлгээтэй холбогдох мэдээлэл хүргэх

14.1. Үнэт цаас гаргагч холбогдох хууль тогтоомжид заасан мэдээллийг нийтэд хүргэх, хөрөнгө оруулагчид өгөх үүрэгтэй.

16 дугаар зүйл. Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад хориглох үйл ажиллагаа

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд

19 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, тэдгээрийн нийтлэг чиг үүрэг

19.2. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага дараахь нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.2.4. өөрийн гишүүн болон үнэт цаас гаргагч, бусад оролцогч этгээд хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг Хороонд хүргэх, тухай бүр олон нийтэд мэдээлэх;

19.2.5. хагас жилийн болон аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж, Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргэх, жилийн эцсийн тайлангийн хураангуйг хэвлэлд нийтэлж, хөрөнгө оруулагчид мэдээлэх;

21 дүгээр зүйл. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага

21.3.3. үнэт цаасны арилжааны болон үнэ, ханшийн тухай мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэх.

22 дугаар зүйл. Хөрөнгийн бирж

22.3. Хөрөнгийн бирж нь энэ хуулийн 19, 21 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь чиг үүрэгтэй байна:

22.3.4. Хөрөнгийн биржийн гишүүн болон бусад харилцагчийг мэдээллээр хангах;

114. ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ

2006 "н 05 – ^ph' 25 S p
с рЦБ' "pS". о'^^'ф^^^p>”~

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

6 дугаар зүйл. Химийн хорт болон аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах

6.1.10. химийн хорт болон аюултай бодисын асуудлаар олон улсын байгууллагатай мэдээлэл солилцох, эдгээр бодисын физик, химийн болон хор аюулын шинж чанар, осол, эрсдлийн үед авах арга хэмжээ, тухайн бодис, түүний хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх аргын талаархи мэдээллээр иргэдийг хангах;

115. ХОРШООНЫ ТУХАЙ

*/ҮЦ'эЩЦ'—э' "Ър—' <^/
1998 "н 1 SA<ээр — ^рн' 8- 'н S p
o '^^'±^^^~^p> " ~*

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хоршоог татан буулгах

40 дүгээр зүйл. Хоршоо татан буугдсаныг мэдэгдэх

- 40.2. Хоршоо татан буугдсаныг улсын бүртгэлд тэмдэглүүлсэн тухай татан буулгах комисс нийтэд мэдээлнэ.

116. ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ

*1999 "н 05 S—< ^p — ^рн' 14- 'ЦБ S p
o '^^'±^^^~^p> " ~*

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХАМТЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР

9 дүгээр зүйл. Мэдээллээр хангах

- 9.1. Хамтын гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах, хэлэлцээ хийх үед төрийн холбогдох байгууллага, ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдөд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

17 дугаар зүйл. Хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлтэд талууд хяналт тавих

- 17.3. Талууд хяналт хэрэгжүүлэхдээ хамтын гэрээ, хэлэлцээрт холбоотой өөрт байгаа бүх мэдээллийг харилцан солилцох үүрэгтэй.

117. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

*2001 "н 04 SA<ээр — ^рн' 19- 'ЦБ S p
o '^^'±^^^~^p> " ~*

5 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр

- 5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ дараахь хэлбэрээр хэрэгжинэ:

- 5.2.1. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг судлах, хөдөлмөр эрхлээгүй иргэдийн судалгаа гаргах, тэднийг бүртгэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллээр хангах;

/Энэ заалтыг 2006 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ

7 дугаар зүйл. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах

- 7.1. Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн алба нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн иргэдэд ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох, давтан сургалтад хамрагдах нөхцөл, боломжийн талаар зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлтэй холбогдох шаардлагатай мэдээллээр хангана.



118. ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ

1995 "н 10 S—<^p 24- ЦБ S p
o'^(^):^(^)^p>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Танхимын зорилт, бүрэн эрх, тогтолцоо

4 дүгээр зүйл. Танхимын зорилт, бүрэн эрх

3. Танхим нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараахь үйл ажиллагаа явуулна.
 - б/ аж ахуйн нэгж, байгууллагууд зөвлөлгөө өгөх, үйлдвэр, худалдааны түнш эрх олохтой холбогдсон мэдээллээр хангах, боловсон хүчин бэлтгэхэд нь туслах болон бусад үйлчилгээ үзүүлэх;

119. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

2003 "н 05 S—<^p —^ph' 23- н S p
o'^(^):^(^)^p>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Бүртгэх байгууллага, түүний чиг үүрэг

8 дугаар зүйл. Бүртгэх байгууллагын чиг үүрэг

- 8.1. Бүртгэх байгууллага дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 8.1.1. хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт орсныг улсын бүртгэлд бүртгэх, энэ тухай хуульд заасны дагуу нийтэд мэдээлэх;

120. ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ

2001 "н 11 SA<эep —^ph' 08- н S p
o'^(^):^(^)^p>”~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хуулийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх, зохион байгуулах, САНХҮҮЖҮҮЛЭХ

6 дугаар зүйл. Хуулийн төсөл боловсруулах талаар хууль санаачлагчийн бүрэн эрх

- 6.1. Хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулах талаар дараахь бүрэн эрх эдэлнэ:
 - 6.1.5. хуулийн төсөл, түүнийг боловсруулах ажлын явцын талаар шаардлагатай гэж үзвэл олон нийтэд мэдээлэх;

121. ХҮНСНИЙ ТУХАЙ

/үЦ'эЦЦ'—э' ”Ъp—'<^/
1999 "н 10 S—<^p —^ph' 07- н S p
o'^(^):^(^)^p>”~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, түүний тогтолцоо

16 дугаар зүйл. Хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих дотоодын болон олон нийтийн хяналт

- 16.2. Иргэн, төрийн бус байгууллага хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг төрийн захиргааны болон хяналтын эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийг сэрэмжлүүлнэ.

122. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

1996 "н 5 S—<^p—^ph' 7-н S p
o'^(^)^p>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хүүхдийн эрхийг хамгаалахад төр, олон түмний оролцоо

11 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийг хамгаалах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хэрэгжүүлэх бүрэн эрх

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хүүхдийн эрхийг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 2/ хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах арга хэмжээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, түүний үр дүнг олон нийтэд мэдээллэх;
- /Энэ заалтад 2003 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

ТАВДУГААР БҮЛЭГ

Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага, түүний чиг үүрэг

19 дүгээр зүйл. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үүрэг

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл дараах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ:

- 4/ хүүхдийн төлөө сан байгуулж, түүний орлого, зарлагын төсвийг батлах гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах, олон нийтэд мэдээлэх;

123. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

2003 "н 12 S—<^p—^ph' 26-н S p
o'^(^)^p>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг

19 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагын чиг үүрэг

- 19.1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага дор дурдсан чиг үүрэгтэй:
- 19.1.1. хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулж болзошгүй барааны үйлдвэрлэлт, борлуулалтыг зогсоох тухай үндэслэл бүхий саналаа холбогдох эрх бүхий байгууллагад тавих, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сэрэмжлүүлэн мэдээлэх;
- 19.1.8. хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг шалгах, дүнг нийтэд мэдээлэх;
- 19.1.10. барааны чанар, аюулгүй байдал, зах зээлийн үнийн тухай хэрэглэгчид мэдээлэл, зөвлөгөө өгөх.



124. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ

1998 "н 5 S—<^p—^ph' 7-н S p
o'^^:±^^~^p>"~

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогчид, тэдгээрийн эрх, үүрэг

16 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогчдын нийтлэг эрх, үүрэг

- 16.1.2. хуулиар хамгаалсан нууцаас бусад мэдээллийг чөлөөтэй олж авах;
- 16.1.3. холбогдох хууль тогтоомжоор төрийн буюу байгууллагын нууцад хамааруулаагүй тохиолдолд эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлынхаа үр дүнг нийтэд мэдээлэх;

125. ШУУДАНГИЙН ТУХАЙ

2003 "н 05 S—<^p—^ph' 15-н S p
o'^^:±^^~^p>"~

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Үйлчлэгч, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

16 дугаар зүйл. Үйлчлэгчийн эрх, үүрэг

- 16.3. Үйлчлэгч нь дараахь үүрэгтэй:
 - 16.3.3. шуудангийн үйлчилгээ үзүүлэхээр тогтоосон хугацаа, журмын тухай мэдээллийг үйлчлүүлэгчид гаргаж өгөх буюу мэдээлэх;

3. Олон нийтэд мэдээлэл хүргэх үүргээ биелүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр заасан хэм хэмжээ

126. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ

2000 "н 05 S—<^p—^ph' 05-н S p
o'^^:±^^~^p>"~

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага

- 24 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага
- 24.1. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан шүүгч, аялал жуулчлалын улсын байцаагч нь дараахь захиргааны шийтгэл ногдуулна:
 - 24.1.4. аялал жуулчлалын талаархи мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хугацаанд нь гаргаж өгөөгүй албан тушаалтныг 10000 хүртэл, байгууллагыг 50000 хүртэл төгрөгөөр торгох;

127. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

2002 "н 12 S—<^p—^ph' 12-н S p
o'^(^)^&^~^p>"~

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хариуцлага

20 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 20.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны хянан шалгагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:
 - 20.1.6. тайлан, тэнцэл, мэдээ баримтыг Монголбанкинд зохих журмын дагуу гаргаж өгөөгүй буюу энэ хуулийн 15 дугаар зүйлийн дагуу нийтэд мэдээлэх санхүүгийн тайланг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийтэд мэдээлээгүй бол банк бус санхүүгийн байгууллагыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
 - 20.1.8. нийтлүүлсэн тайлан мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол тухайн банк бус санхүүгийн байгууллага буюу уг тайлан мэдээллийг нийтлүүлэх үед ажиллаж байсан гүйцэтгэх захирлыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
 - 20.1.9. энэ хуулийн 12.1.2.-т заасныг зөрчин хуурамч, худал, ташаа мэдээлэл бүхий зар сурталчилгааг тараасан бол тухайн банк бус санхүүгийн байгууллагыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, уг зар сурталчилгааг тараах үед ажиллаж байсан гүйцэтгэх захирлыг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

128. БАНКНЫ ТУХАЙ

1996 "н 9 SA<ээр—^ph' 3-н S p
o'^(^)^&^~^p>"~

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хариуцлага

49 дүгээр зүйл. Монголбанкны хянан шалгагчаас хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Банкны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны хянан шалгагч дараахь хариуцлага ногдуулна:
 - 6/ тайлан, тэнцэл, мэдээ баримтыг Монголбанкинд зохих журмын дагуу гаргаж өгөөгүй буюу энэ хуулийн 281 дүгээр зүйлийн дагуу нийтэд мэдээлэх санхүүгийн тайланг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийтэд мэдээлээгүй бол банкиг 1000000 хүртэл төгрөгөөр, ажилтан, албан тушаалтныг 250000 хүртэл төгрөгөөр торгох;
/Энэ заалтыг 1998 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан мөн энэ заалтад 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/
 - 8/ нийтлүүлсэн тайлан мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол тухайн банк буюу уг тайлан мэдээллийг нийтлүүлэх үед ажиллаж байсан гүйцэтгэх захирлыг 250000 хүртэл төгрөгөөр торгох.



/Энэ заалтыг 1998 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/
9/ энэ хуулийн 71 дүгээр зүйлийг зөрчин хуурамч, худал ташаа мэдээлэл бүхий зар сурталчилгааг тараасан бол тухайн банкиг 1000000 хүртэл төгрөгөөр, уг зар сурталчилгааг тараах үед ажиллаж байсан гүйцэтгэх захирлыг 250000 хүртэл төгрөгөөр тус тус торгох.

/Энэ заалтыг 1998 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

4. Олон нийтийн эрх, ашиг сонирхолтой холбоотой буюу түүнийг ямар нэг хэлбэрээр зөрчиж байгаа тухай мэдээллийг хянан шалгаж хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтанд заавал мэдэгдэх үүргийг тодорхой субъектүүдэд ногдуулсан хэм хэмжээ

129. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ

2006 "н 07 – рн' 06 S p
с рЦБ' "pS". о'^^'ф^^^'р>"~

ХОЁРДУГААР БҮЛЭГ

8 дугаар зүйл. Авлигын тухай мэдэгдэх

- 8.1. Дараахь албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаархи мэдээллийг нэн даруй Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй:
 - 8.1.1. шүүгч;
 - 8.1.2. прокурор;
 - 8.1.3. цагдаа, тагнуулын байгууллагын албан тушаалтан;
 - 8.1.4. төрийн аудитын болон мэргэжлийн хяналтын байгууллагын албан тушаалтан;
 - 8.1.5. төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан.

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ЗАРИМ ВЭБ САЙТ

www.iltod.gov.mn

www.legalinfo.mn

www.pmis.gov.mn

www.pmis.gov.mn/presi_mon.htm

http://www.pmis.gov.mn/parl_mon.htm

http://www.pmis.gov.mn/gov_mon.htm

http://www.pmis.gov.mn/sup_mon.htm

<http://www.open-government.mn/phpgov/>

<http://www.pmis.gov.mn/cabinet/>

<http://www.mof.pmis.gov.mn/>

<http://www.mojha.gov.mn/>

<http://www.mfa.gov.mn/>

<http://www.mhud.gov.mn/>

<http://www.moh.mn/>

http://gate1.pmis.gov.mn/mofa/web/index.php?top_id=2&add_true

<http://www.mit.pmis.gov.mn/>

<http://www.mfe.energy.mn/>

<http://www.mswl.pmis.gov.mn/>

<http://www.mrtt.pmis.gov.mn/>

<http://mecs.pmis.gov.mn/>

<http://www.mdef.pmis.gov.mn/>



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. 1-р боть. 2004 он.
2. Төрийн ил тод байдал, нийгмийн баялаг хуваарилалт. Форум. 2006 он.
3. Монгол Улс шилжилтийн үед -Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ. "Нээлттэй нийгэм форум", "Глоб интернэшнл" ТББ. 2003 он.
4. "Мэдээллийн эрх чөлөө". Иргэдэд зориулсан гарын авлага. 2005 он.
5. НҮБ-ын Ерөнхий Ассемблейн анхдугаар чуулга уулзалтын тогтоол, № 59, 1946
6. Олон нийтийн мэдэх эрх. Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн зарчмууд, 19-р зүйл байгууллага, Лондон, 1999
7. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн загвар, 19-р зүйл байгууллага, Лондон, 1999
8. Мэдээлэл олж авах тухай хуулийн төсөл боловсруулах нь. Төв болон Зүүн Европ, ТУХН-ын орнуудын чиг хандлага, 19-р зүйл байгууллага, Лондон, 1999
9. Йоханнесбургийн зарчмууд, Үндэсний аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж, 1995, 19-р зүйл байгууллага, Цагдан хяналтын эсрэг олон улсын төв
10. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих олон улсын механизмууд, НҮБ-ын тусгай элч, Европын Аюулгүй Байдлын Байгууллагын (OSCE) эрх чөлөөний төлөөлөгч, Америкийн Улсуудын Байгууллагын (OAS) эрх чөлөөний тусгай элч нарын Хамтарсан тунхаглал, 2000 он
11. Монгол Улсын Үндсэн Хуулийн тайлбар
12. Монгол Улс шилжилтийн үед. Үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ, 19-р зүйл байгууллага, Глоб Интернэшнл. 2001, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн. 2003 он.
13. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, "Сэтгүүлч ба хууль" цуврал № 03, Глоб Интернэшнл. 2001
14. Марк Гармбергер. "Иргэн түншлэгч болох нь" гарын авлага, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, 2001
15. Е.Янг, Л.Квин " Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь", Нээлттэй нийгэм хүрээлэн, 2002
16. Ардчиллыг бүх нийтэд, МННХ, 2000
17. " Мэдээллийн эрх чөлөө" хууль боловсруулагч, тогтоогчдод зориулсан гарын авлага "Глоб Интернэшнл" ТББ. 2002 он

ГАРЧИГ

СЭТГҮҮЛЧ ТАНАА.....	3
ТӨР СЭТГҮҮЛЧИД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮҮРЭГ ХҮЛЭЭДЭГ ҮҮ?	4
СЭТГҮҮЛЧ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ МАНАЙД ХЭРХЭН БАТАЛГААЖУУЛСАН БЭ?	5
ТӨР МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ ШААРДЛАГАТАЙ ЮУ?	6
ТӨР, БАЙГУУЛЛАГА, ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЯМАР ЗОХИЦУУЛАЛТ БАЙДАГ ВЭ?	7
АЛИВАА БАЙГУУЛЛАГА МЭДЭЭЛЛЭЭ НУУЦЛАХ ҮНЭМЛЭХҮЙ ЭРХТЭЙ ГЭСЭН ҮГ ҮҮ?	8
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ДОТООДЫН ЯМАР САЛБАР ХУУЛИУДААР ЗОХИЦУУЛСАН БАЙДАГ ВЭ?	9
МЭДЭЭЛЭЛ АВАХ МИНИЙ ЭРХ ЗӨРЧИГДВӨЛ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БИЙ ЮУ?	11
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ ТУСГАЙЛСАН ХУУЛИАР ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ЮУ?	12
СЭТГҮҮЛЧ ТАНД ЗӨВЛӨХ НЬ	15
МЭДЭЭЛЭЛ НЭЭЛТТЭЙ БАЙХ ХЭМ ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛСОН ХУУЛИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫН ТҮҮВЭР	16
1. Олон нийтэд мэдээлэл заавал хүргэх үүрэг хүлээлгэсэн хэм хэмжээ... 16	
2. Тодорхой мэдээллийг олон нийтэд заавал хүргэх үүрэг хүлээлгээгүй боловч нээлттэй байлгах үүрэг хүлээлгэсэн хэм хэмжээ.....	41
3. Олон нийтэд мэдээлэл хүргэх үүргээ биелүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр заасан хэм хэмжээ.....	67
4. Олон нийтийн эрх, ашиг сонирхолтой холбоотой буюу түүнийг ямар нэг хэлбэрээр зөрчиж байгаа тухай мэдээллийг хянан шалгаж хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтанд заавал мэдэгдэх үүргийг тодорхой субъектүүдэд ногдуулсан хэм хэмжээ.....	69
ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ЗАРИМ ВЭБ САЙТ	70
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	71



